Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Монголын эдийн засаг, санхүү, бизнесийн сэтгүүл 2013. 01 сар. №01(035) www.mongolianeconomy.mn

Чингис бондын чиг

Нөлөөллийн гурвалжин буюу ОПС

Усан зэрэглээт говь



ХИЙЖ БҮТЭЭВЭЛ "БҮГД ИРНЭ"

MONGOLIAN ECONOMY

“Mongolian Economy” сэтгүүл Давосын Дэлхийн эдийн засгийн чуулганд

2013.01.23-27

2013.01.23-27

WORLD ECONOMIC FORUM

COAL MONGOLIA 2013

THE THIRD INTERNATIONAL COAL INVESTORS CONFERENCE AND EXHIBITION

Organizers:

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР MINISTRY OF MINING

MINING.MN

Within "COAL MONGOLIA-2013" Conference and Exhibition, we are organizing one day field trip to Ukhaa Khudag of "Mongolian Mining Corporation" and "Erdenes Tavan Tolgoi" coal mining site on February 23, 2013.

REGISTRATION NOW OPEN


2013.02.23

MONGOLIAN MINING CORPORATION

UKHAA KHUDAG - MONGOLIAN MINING CORPORATION

www.mmc.mn





YOU WILL VISIT TWO LARGEST COAL MINING SITES IN ONE FIELD TRIP

ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ERDENES-TT

"ERDENES-TAVANTOLGOI" JSC

www.erdenestt.mn















For more information:
Tel: +976-70115590, Fax: +976-70125590
Email: registration@coalmongolia.mn, Web site: www.coalmongolia.mn

Нөгөөн хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:
И.Отгонжаргал /8800-6228/

□□□□□□□□□□□□□ □□□□□□ □□□□□□□ □□□□□
Б.Энхмарт

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР: Теренс Эдвардс

ОРЧУУЛАГЧ: □.□үмэнбаяр
Б. Заяа

СЭТГҮҮЛЧИД: Б.Баяртогтох
Б.Энхцэцэг
Э.Зоригт
Б.Уганбаяр
Х.Хулан
Б.Үүрийнтуяа

ДИЗАЙНЕР, ВЭБ МАСТЕР: Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР: Д.Барианжав /8880-0825/
□.□□□□□□□□ /9902-2279/
Б.Энхцэцэг /9901-5476/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР: С.Цэнд-Аюуш

“ECONOMY” ТВ СТУДИ

ЗУРАГЛААЧ: Ц.Бат-Отгон
ГРАФИК ДИЗАЙН Г.Буянбаатар

ХАЯГ:
Улаанбаатар, ЧД IV хороо,
Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762
www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

ÁÎÐËÓÓËÀÕ ÖÝÃ¯Ä:
"Интер ном"
"Цэцэг төв"
"Минж плаза"
"Алтантүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Преско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар
"Max mall" □□□□□□□□□□

“Óëàáàòàð ïðèíò” ÕÕÊ-ä õýâëýâ
www.ubprint.mn

www.mongolianeconomy.mn

ОНЛАЙН ЗАХИАЛГА

УТАС: 7011-5476
8880-0825
9902-2279

МОНГОЛ ОД ТОГЛОГЧ



Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2013 онд Дэлхийнбанк 16.2 хувь, Олон улсын валютын сан 16.8 хувь байна хэмээн төсөөлсөн бол Азийн хөгжлийн банк 12 хувь байна гэж таамаглаад буй. ..12

Нөлөөллийн гурвалжин буюу ОПС



Өөрчлөлтөөс, өөр орны түншүүдээс бүү ай



Энэ бол ерөөсөө л олон улсын сангууд, компаниудыг авчирч тэдэнтэй хамтарч ажиллаж, тогтоон барьж улмаар хурдтай гэвч тэсвэртэй стратегийн зөв төлөвлөлт бүхий арга замаар урагш ахих тухай л асуудал юм. ..26

Гол дүр

Монголын уудам говь нутаг Сахарын цөлийн дараа орох хэмжээний нар, салхины нөөцтэй. АНУ-ын Үндэсний сэргээгдэх эрчим хүчний лабораторийн тооцоогоор Монголын нар, салхинаас нийт 2,6 сая мВт эрчим хүч үйлдвэрлэх боломжтой аж. ..39



ЭДИЙН ЗАСАГ

10 Чингис бондын чиг

12 Монгол од тоглогч

14 Эрдэнийн эзэд

16 ДНБ-ээс гаднах баялаг

20 Нөлөөллийн гурвалжин буюу ОПС

26 Өөрчлөлтөөс, өөр орны түншүүдээс бүү ай

30 Уул уурхайн салбарт шинэ эрин үе эхэллээ

33 Эрүүл мэндийн даатгал, Германы туршлага

35 Түүхий эдээ хөгжлийн тулгуур болгох нь чухал

НОГООН ЭДИЙН ЗАСАГ

39 Гол дүр

42 Усан зэрэглээт говь

44 Зүс нь Монгол, зүрх нь Монгол

COAL MONGOLIA 2013

НҮҮРСНИЙ САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН 3 ДАХЬ УДААГИЙН ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ, ҮЗЭСГЭЛЭН

Зохион байгуулагч

УУЛ УУРХАЙН ЯАМ

MINING.MN

"COAL MONGOLIA-2013" чуулга уулзалт, үзэсгэлэнгийн хүрээнд 2013 оны 2 дугаар сарын 23-ний өдөр "Mongolian Mining Corporation"-ы Ухаа Худаг, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн нүүрсний уурхайтай танилцах аяллыг зохион байгуулах гэж байна.

БҮРТГЭЛ ЯВАГДАЖ БАЙНА


2013.02.23

MONGOLIAN MINING CORPORATION

УХАА ХУДАГ - MONGOLIAN MINING CORPORATION

www.mmc.mn





НЭГ УДААГИЙН АЯЛЛААР МОНГОЛЫН ХАМГИЙН ТОМ ХОЁР УУРХАЙТАЙ ТАНИЛЦАНА

ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ
ERDENES-TT

"ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ" ХК

www.erdenestt.mn















Дэлгэрэнгүй мэдээллийг:
Утас: +976-70115590, Факс: +976-70125590
Э-шуудан: registration@coalmongolia.mn, Веб сайт: www.coalmongolia.mn

Зохион байгуулагч:

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР УУЛ УУРХАЙН ЯАМ

MINING.MN

COAL MONGOLIA 2013

2013 оны 2 сарын 21-22

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, SS CONVENTION CENTER

"COAL MONGOLIA-2013" ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТЫН ОНЦЛОГ:

- Шинэчлэлийн Засгийн газар нүүрсний салбарт баримтлах бодлого
- Нүүрс олборлолт, үйлдвэрлэлт болон боловсруулалтад хөрөнгө оруулах шинэ боломжууд ба төслүүд
- Хамтын ажиллагаа- Монголын нүүрсийг олон улсын зах зээл дээр гаргах
- Уул уурхайн салбарт байгаль орчинд ээлтэй, шинэ дэвшилтэд техник, технологийг нэвтрүүлэх

НҮҮРСНИЙ САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН 3 ДАХЬ УДААГИЙН ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ, УЗЭСГЭЛЭН

Platinum sponsor

MONGOLIAN MINING CORPORATION

HERA Equipment LLC OFFICIAL DISTRIBUTOR OF Wirtgen

Diamond sponsor

HUNNU COAL

Gold sponsor

ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ERDENES-TT

GEMCOM

XacBank Right Bank

GLOGEX Geology & Mining Consulting Services

БАГАНУУР ХК

ШИВЭЭ ОВОО ХК

MoEnCo MONGOLIA ENERGY CORPORATION

ASPIRE MINING LTD

TERRA ENERGY

Bank of the Event

TDB TRADE & DEVELOPMENT BANK

Event sponsor

KHAN BANK YOUR TRUSTED FRIEND

WAGNER CAT

MINES UP

carhartt Exclusive distributor

TRANSWEST MONGOLIA LLC

MobiNet leading internet technology

GOLOMT BANK Committed to and Investing in Excellence

Deloitte.

Supporting organizations

THE BUSINESS COUNCIL OF MONGOLIA

Mongolian Mining Club

ZAZA CORPORATE COUNSEL LLC

NAMBC

International media partners

Bloomberg TV MONGOLIA

InfoMine

ASIA Miner

РАЦИОНАЛЬНОЕ ОСВОЕНИЕ НЕДР

BAIINFO

COAL INTERNATIONAL

ChinaMineral

COAL SPOT.COM

WORLD COAL

MiningJournal

commodity

MINING LEADERS

globalCOAL

BULKINSIDE

ASIA TODAY

Mining People Environment

Local media partners

MONGOLIAN ECONOMY

MONTSAME

MINING

iRMUUN

ӨГЛӨӨНИЙ СОНИН

ГЭМЭГТ УУЛ УУРХАЙН МЭДЭЭ

БАЯЛАГ

Дэлгэрэнгүй мэдээллийг:

www.coalmongolia.mn, +976-70115590

БҮРТГЭЛ ЯВАГДАЖ БАЙНА

БИЗНЕС



Америкийн “Өв” сан “Wall Street Journal” сонинтой хамтарч жил бүр эдийн засгийн чөлөөт хотыг тодруулдаг. Ингэхдээ эдийн засаг, чөлөөт худалдаа, хөрөнгө оруулалтын нээлттэй байдал, эдийн засгийн хөндлөнгийн оролцоо, авлига зэрэг үзүүлэлтийг голчлон авч үздэг байна. Судалгаанд 177 улс, хотыг хамруулснаар 89.3 оноогоор Хонконг тэргүүлжээ. Сингапур 88 оноогоор удаалсан бол айрагийн тавд Австри, Шинэ Зеланд, Швейцарь багтлаа. Харин Хятад 136-д бичигдэж, манай хойд хөрш 139-дүгээр байранд жагсжээ. Эдийн засагт “ээлгүй” орноор Зимбабве, Куб, Хойд Солонгос “манлайлж” байна.

САНХҮҮ

Нөөцөө бүрэн тогтоохоор ажиллаж байгаа Сэлэнгэ аймгийн “Харанга ресурс” төмрийн хүдрийн хайгуулын компани хайгуулын лиценз авахын тулд зургаан сая ам.долларын санхүүжилт босгохоор болжээ. Ингэхдээ 30 сая ширхэг хувьцааг тус бүрийг нь 0.20 австрали доллараар дотоодод зарахаар тооцоолсон байна. Ийнхүү тус компани босгосон хөрөнгөөрөө дээрх ордын болон төмөр ялгах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг хийх аж.



АЖ ҮЙЛДВЭР


Газрын тосны бүтээгдэхүүний импортыг бууруулж, Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах "Дархан газрын тос" боловсруулах үйлдвэрийг 2015 онд барьж дуусгахыг холбогдох яамдад Засгийн газраас үүрэг болгосон. Жилд хоёр сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай, төрийн өмчийн оролцоотой тус үйлдвэрийг түлхүүр гардуулах нөхцөлөөр Японы “Тоёо инженеринг” корпораци хамгийн сүүлийн үеийн технологиор, Монголын туслан гүйцэтгэгч компаниудын оролцоотой барьж, байгуулах юм. Шатахууны өнөөгийн ханшийг найм хүртэлх хувиар бууруулах боломжтой уг үйлдвэр анхны хөрөнгө оруулалтаа дөрвөн жилийн хугацаанд нөхнө хэмээн тооцоолж байна.

ЭРЧИМ ХҮЧ

Уул уурхайг дагасан өмнөд бүсийн эрчим хүчний хэрэглээ өссөнтэй холбогдуулан Өмнөговь аймгийн нутаг дахь цахилгаан түгээх өндөр хүчдэлийн шугам сүлжээ, дэд станцын үйл ажиллагааг хариуцан ажиллах “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” компанийг Засгийн газраас шинээр байгуулахаар боллоо. Таван өөр эх үүсвэрээс цахилгаан авдаг тус бүсийн хэрэглэгчид мөн тооны өөр тарифаар хэрэглээний хөлсөө төлдөг байна. Иймд өмнөд бүс дэх 15 сум, гурван том уурхайн цахилгаан хангамжийн болон түгээх сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах мэргэжлийн байгууллага шаардлагатай аж.

ДЭД БҮТЭЦ

Өнгөрсөн онд “Чингис хаан” олон улсын нисэх буудлаар үйлчлүүлсэн зорчигч урсгал өмнөх оны дүнгээс 27 хувиар өссөн бол ачаа тээвэрлэлт долоон хувиар нэмэгджээ. Түүнчлэн манай улсын нутаг дэвсгэрийг дайран өнгөрч буй нийт нислэгийн тоо 82,627 болсон нь өнгөрсөн онтой харьцуулахад зургаан хувиар өссөн тоо аж. Монгол Улсын агаарын зайд үйлдэж буй олон улс, орон нутгийн нислэгийн аюулгүй байдал болон үйл ажиллагааг хангахаар энэ салбарт хийсэн техник технологийн шинэчлэлт, бүтээн байгуулалттай холбоотой зохих ажлуудыг хийсэн нь дээрх үзүүлэлтэд нөлөөлсөн байна.





ХЯТАД

Хятад улс энэ ондоо багтаж Олон улсын сэргээгдэх эрчим хүчний агентлаг (ОУСЭХА)-ийн бүрэн эрхт гишүүн болох хүчтэй хөдөлгөөнийг өрнүүлж эхэллээ. 2009 онд байгуулагдсан тус агентлаг нь гишүүн орнуудынхаа дунд хамтын ажиллагаа, мэдлэгийг дээшлүүлэн салхи, нар, ус ба био хаягдал зэргээс эрчим хүч гарган авах үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Хятад улс ажиглагчын байр сууринаас оролцоор иржээ.

Дэлхийн эдийн засгийн удаашрал, евро бүсийн өрийн хямралаас үл хамааран Хятад, Их Британийн эдийн засаг, худалдааны харилцаа эрс сайжирчээ. Хоёр улсын хоорондох бараа бүтээгдэхүүний худалдаа өнгөрсөн онд 63.1 тэрбум ам.долларт хүрсэн нь 2011 онтой харьцуулахад 7.5 хувиар өссөн үзүүлэлт юм. Хятадаас Их Британи руу экспортолсон бараа бүтээгдэхүүний үнэ 46.3 тэрбум ам.доллар буюу 4.9 хувиар, Британис Хятад руу экспортолсон барааны үнэ 16.8 тэрбум ам.доллар буюу 15.5 хувиар тус тус өсчээ.

ОРОС

Оросын цахим худалдааны эргэлт



өнгөрсөн онд 12 тэрбум ам.доллар байсан бөгөөд 2015 он гэхэд тус тоог гурав дахин нэмэгдүүлж 26 тэрбум ам.доллар болгохоор зорилт тавин ажиллаж байгаа талаар “Morgan Stanley” санхүүгийн үйлчилгээний корпораци мэдээлжээ. Одоогийн байдлаар нийт худалдааны 1.9 хувь буюу 12 тэрбум ам.долларын худалдааг цахим хэлбэрээр явуулдаг бол 2015 он гэхэд энэ тоо 4.5 хувь болох төлөвтэй байна.

Грек төрийн өмчит газрын тосны компаниа ОХУ-д 1.5 тэрбум еврогоор худалдана гэх мэдээг RT цахим хуудастаа нийтэлжээ. Европын холбоо болон АНУ-ын удирдагчид ОХУ-ын худалдаа Грекийн зах зээлд хэт тэлж буйг эсэргүүцэж байгаагаа мэдэгдсэн. Гэсэн ч их гүрнүүдийн анхааруулгыг үл ойшоон тус худалдааг хийх болсон шатгааныг Грекийн өрийн хямралаас гарах оролдлого гэх шинжээчид буй аж. Герман, Хятад, Япон, Израйлийн компаниуд саналаа хүргүүлээд байгаа ч эцсийн үнийн саналаа өгөөгүй байна. ■

А.АМАРСАЙХАНЫ БУЛАН



Шог зургийг А.Амарсайхан

Тойм

ЧИНГИС БОНДЫН ЧИГ

И.ОТГОН

Албаны мэдээллээс үзэхэд 2022 оны арванхоёрдугаар сарын 5-ны өдөр гэхэд “Од тоглогч” гэгдэх Монгол Улс олон улсын зах зээлээс босгосон 1.5 тэрбум ам.долларын бонд буюу их өрийн бичгийнхээ ард нэр төртэйгээр гарсан байх учиртай.



Он гарснаас хойших 14 хоногт Монголын эдийн засгийн “амьдрал” өрнүүн байв. Өрнөж буй үйл явдлын ихэнх нь Чингис бондын зарцуулалтын чиг гарсантай холбоотой гарч ирж байна. Албаны мэдээллээс үзэхэд 2022 оны арванхоёрдугаар сарын 5-ны өдөр гэхэд “Од тоглогч” гэгдэх Монгол Улс олон улсын зах зээлээс босгосон 1.5 тэрбум ам.долларын бонд буюу их өрийн бичгийнхээ ард нэр төртэйгээр гарсан байх учиртай. Тэгэхийн тулд эхнээсээ зарцуулалтыг зөв хийх өндөр хариуцлага төр, засгийн эрх мэдэлтнүүдэд ногдож буй. Ерөнхий сайд Н.Алтанхуяг шинэ оны эхэнд бондын талаар Парламентын танхимд танилцуулга хийсэн нь өнгөрч буй өдрүүдэд бондоор амьсгалах эхлэлийг тавьсан гэж үзэж болно. Түүний мэдээлэлтэй холбоотой хамгийн түрүүлж УИХ-ын гишүүд бондын талаар шаггүй мэдээлэлтэй болоод авах шиг болсон. Гишүүдийн дундаас “Бонд арилжихад оролцсон Засгийн газрын гишүүд та бүхэнд юу хийчих вэ гэсэн айдас байгаа юу” хэмээн хүртэл сонирхоод, сонжоод авсан. Монгол хүн бүр улсаараа өрөнд орчих вий дээ гэсэн болгоомжлол тээн байгаа энэ үед дээрх нь сонирхох л асуудал.

Үүнд Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр хэлэхдээ “Бонд арилжиж мөнгөтэй болсноор энэ удаагийн Засгийн газар мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх боломжтой болж байгаа юм. Анхнаасаа бондыг гаргах гэж санаачилсан, зохион байгуулсан, үр дүнг нь үзэхээр тооцоо судалгаа гаргасан тул айдас алга” хэмээн хариулсан.

Харин бондын зарцуулалтын тухайд Ерөнхий сайдаар ахлуулсан Засгийн газрын холбогдох сайд нар, албаныхан оролцсон арав гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг бондын хөрөнгөөр санхүүжих төслүүдийн хар зургийг энэ сарын эхээр олон нийтэд задаллаа. Үүнд: 2013 онд багтааж зургаан аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай замаар холбох, 1800 км шинэ төмөр зам барих, МИАТ компанийн парк шинэчлэлтэд зориулж онгоц худалдан авах, Улаанбаатар хотыг хөндлөн огтолж гарсан төмөр замын ачааллыг багасгах зорилгоор Богд уулын урдуур шинээр төмөр зам тавих, Нефть боловсруулах үйлдвэр барих, “Эрдэнэс Тавантолгой” компанид шаардлагатай хөрөнгө оруулалт хийх, Цементийн хэрэглээг дотоодын үйлдвэрүүдээс 100 хувь хангадаг болоход санхүүгийн дэмжлэг үзүүлэх, Төмөрлөгийн үйлдвэрийн цогцолбор барих, “Сайншанд” аж үйлдвэрийн парк байгуулах, Томоохон нүүрсний ордуудыг түшиглэн цахилгаан станц барих, Сэргээгдэх эрчим хүчний нөөц бололцоог түшиглэн цахилгаан станц барих, Нийслэл хотод газар доорх байгууламж, Метро барих, Хотын эрчим хүчний хэрэглээг зөв зохицуулах зэрэг 17 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Энэ гэхдээ эцэслэн шийдэгдсэн зүйл биш, хар зураг гэдгийг хаа хаанаа сануулж буй. Үүнтэй холбоотойгоор нэг хэсэг чимээгүй болсон “Эрдэнэс

Тавантолгой” компанийн шинэхэн гүйцэтгэх захирал Я.Батсуурь тус компанийн санхүүгийн асуудал тун хүнд байгаа тухай мэдээлэл хийсэн нь олны сэтгэлийг эмзэглүүлэв. Улс төрийн намуудын мөнгөний амлалт, БНХАУ-ын “Чалко” компанитай хийсэн үнэлгээ багатай гэрээ хоёроос болж “Эрдэнэс Таватолгой” компанийн үйл ажиллагаа зогсонги байдалд оржээ. Үүнээс гадна тус компанийн өмнөх захирлууд нэг бүр нь 160 сая төгрөгийн үнэтэй хүнд даацын 10 автомашин, таван тэрбум төгрөгийн өртөгтэй дугуй гээд нийт долоон тэрбум төгрөгийн ашиглах боломжгүй бараа “шахсан” гэсэн мэдээлэл нь төрийн өмчид удирдлагууд нь хүйтэн хөндий сэтгэлээр ханддагийг харуулж байгаа хэрэг юм. Түүнчлэн “Монголын төмөр зам” ТӨК-ийн гүйцэтгэх захирлаар томилогдоод хоёр сар орчмын нүүр үзэж буй М.Энхсайханыг өнгөрсөн долоо хоногт үүрэгт ажлаас нь чөлөөлснийг хэвлэлийнхэн бондын зарцуулалтын асуудалтай холбон үзэж буй юм. Учир нь, бондын хөрөнгийн нэг хэсгийг төмөр замтай болоход зориулахаар байгаа. Харин энэ онд барих шинэ төмөр замыг Зам, тээврийн яам Тавантолгойгоос зүүн тийш 30 км, Чойбалсангаас баруун тийш 50 км, Сайншандаас баруун зүүн зүгт тус бүр 50 км өргөн царигийн төмөр зам барих төсөл танилцуулж санхүүжилт хүссэн. Харин М.Энхсайхан энд тэнд мухар зам тавьж байхаар нь шууд Тавантолгой Гашуунсухайтыг холбосон 267 км нарийн царигийн зам барьсан нь дээр гэж үзжээ. Мөн тэрбээр тветтер хуудастаа “Би бондын мөнгийг үрмээргүй байна” гэж бичсэн бол нэг бус хэвлэлд түүнийг Засгийн газрын нэгэнт гарсан шийдвэртэй тэрсэлдэж байгаа учраас Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд болон Зам, тээврийн сайд нар ТӨХ-гоор тушаал гаргуулж ажлаас нь чөлөөлж чадлаа гэж бичиж байна. Ямартай ч М.Энхсайхан болон салбарын сайд нарын бондын хөрөнгөөр төмөр зам барих бодлого нэг зүгт биш байгаа нь харагдав.

Мөн оны өмнө шатахууны үнэ нэг литр тутамд 50 төгрөгөөр нэмэгдэж, иргэдийг бухимдуулсан бол он гараад ч энэ асуудал намжсангүй, бензиний үнэ дахин 50 төгрөгөөр нэмэгдэж асуудал гал болон дүрэлзэв. Нефтийн үйлдвэртэй болох асуудлыг яаравчлахгүй бол горьгүй. Харин олзуурхууштай нэгэн шийдвэр Засгийн газраас гарсан нь үүнтэй холбоотой. Монгол Улсыг газрын тосны хараат байдлаас гаргаж, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, шинэчлэлийн Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилго бүхий шийдвэрийг Засгийн газрын хуралдаанаас гаргалаа. Дархан-Уул аймагт жилд 2.0 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай, төрийн өмчийн оролцоотой үйлдвэрийг 2015 он гэхэд барихаар болов. Үйлдвэрийг түлхүүр гардуулах нөхцөлөөр Японы “Тоёо инженеринг” корпораци хамгийн сүүлийн үеийн технологиор, Монголын туслан гүйцэтгэгч компаниудын оролцоотойгоор барьж байгуулна. Тус үйлдвэр нь шатахууныг дотоодын зах зээлд өнөөгийн үнээс 6-8 хувиар хямд борлуулахад үйлдвэрийн анхны хөрөнгө оруулалтаа дөрвөн жилийн хугацаанд нөхөх боломжтой гэсэн тооцоог хийжээ.

Эцэст нь тэмдэглэх ёстой нэг асуудал нь өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт. Өнгөрсөн онд манай нийгэм, эдийн засгийн байдал ямар байсан бэ гэдгийг илтгэх тоон үзүүлэлтийг Үндэсний статистикийн хорооноос өнгөрсөн долоо хоногт мэдээлсэн. Сүүлийн зургаан сард инфляци тасралтгүй өссөнийг эс тооцвол макро эдийн засгийн байдал өнгөрсөн онд тийм ч муу байгаагүй гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Харин инфляци өмнөх оны жилийн эцсээс 14 хувиар өсжээ. Үүнд архи, тамхи, шатахууны үнэ нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн аж. “ Хүнсний гол нэрийн барааны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг Засгийн газар, Монголбанк хамтран хэрэгжүүлж байгаа ч бараа бүтээгдэхүүни й үнэ нэмэгдсээр байна.

Хэлэлцүүлэг зарлаж байна

"Mongolian Economy" сэтгүүл 1.5 тэрбум ам. долларын бондын хөрөнгийн үр ашигтай зарцуулалтын асуудлаар төр, засгийн холбогдох хүмүүс болоод эдийн засаг, бизнесийн салбарын эрдэмтэн судлаач, мэргэжилтнүүдийн дунд хэлэлцүүлэг өрнүүлж байна.

Санал бодлоо **www.mongolianeconomy.mn** сайт болон **info@mongolianeconomy.mn** хаягаар илгээж олон нийттэй хуваалцана уу.



МОНГОЛ
Од тоглогч

Б.ЭНХЦЭЦЭГ

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2013 онд Дэлхийн банк 16.2 хувь, Олон улсын валютын сан 16.8 хувь байна хэмээн төсөөлсөн бол Азийн хөгжлийн банк 12 хувь байна гэж таамаглаад буй. Манай улсын эдийн засгийн өсөлтийн хурд 2012 оны сүүлийн хагаст удааширснаас үүдэн томоохон байгууллагууд ирэх оны эдийн засгийн өсөлтийн таамаглалаа бууруулсан нь энэ.

"The Economist Cassandra" блогийн сүүлд гаргасан таамаглалаас үзэхэд Монгол Улс ирэх онд эдийн засгийн өсөлтөөрөө дэлхийд 18.1 хувийн амжилт үзүүлж, од тоглогчийнхоо байр суурийг хадгалах бол Макао удаалах гэнэ. Харин "Economist Intelligence Unit" компанийн шинжээчид эдийн засгийн өсөлтөөр Макао манлайлж, Монгол араас нь жагсана хэмээн таамаглаж байгаа билээ. Их өсөлтийг жолоодогч нь энэ онд арилжааны олборлолтоо эхлэх гэж буй дэлхийн хамгийн том алт, зэсийн Оюутолгой уурхай байхын зэрэгцээ Хятадын ашигт малтмалын өсөн нэмэгдэж буй эрэлтч тэр томоохон үүрэг гүйцэтгэнэ гэжээ.

Энэ оны төсөвт эдийн засаг бодитоор 18.5 хувиар тэлж, ДНБ-ий хэмжээг 17.6 их наяд төгрөгт хүрэхээр төлөвлөсөн. Нийт экспорт 78 хувиар огцом нэмэгдэж, уул уурхайн олборлолт 60 хувиар өссөнөөр дээрх эдийн засгийн өндөр өсөлтийг бүрдүүлнэ гэж таамаглаж байгаа. Түүнчлэн инфляцийг 2013 онд 8.1 хувьд барихаар Мөнгөний бодлогын баримт бичигт тусгасан юм. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль (ТТБТХ) бүрэн хэрэгжиж эхэлсэн анхны жилийн төсвийн төлөвлөлт болсоноороо онцлог байгаа. Уг төсөвт ТТБТХ-д төсвийн алдагдлыг хоёр хувьд барина гэсэн заалтыг Засгийн газар хэрэгжүүлэхээр тусгасан байгаа билээ. Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банкны аль, аль нь дэлхийн эдийн засгийн байдал тааламжгүй байгаа, Хятад улсын эдийн засгийн сэргэлт тодорхойгүй энэ үед өсөлтийг 18.5 хувь байхаар таамагласан нь хэтэрхий өөдрөг байна хэмээсэн билээ.

Энэ оны эхнээс хэрэгжиж эхэлж буй ТТБТХ-д заасан төсвийн алдагдлын хамгийн дээд хэмжээ нь ДНБ-ий хоёр хувиас илүүгүй байх. Гэсэн ч олон улсын байгууллагууд төсөвт нэмэгдэж болзошгүй зарлагуудаас үүдэн төсвийн алдагдал зургаа ба түүнээс ч дээш хувьд хүрч өсөх талтайг анхааруулж байна.

Дэлхийн санхүүгийн зах зээлийн "гурван том" хэмээн алдаршсан зээлийн рейтинг тогтоогч S&P, Moody's болон Fitch үнэлгээний байгууллагын Монголыг хэрхэн үнэлж, цэнэж буй болон тэдний зүгээс өгч буй анхааруулгыг хүргэж байна.



Монгол Улс таван тэрбум ам.долларын бонд дэлхийн зах зээл дээр борлуулах дунд хугацааны хөтөлбөрийн дагуу 2018 оны нэгдүгээр сар болон 2022 оны арванхоёрдугаар сар хүртэл тус тус хүчинтэй 500 сая ам.доллар болон нэг тэрбум ам.долларын Засгийн газрын өрийн бичиг гаргасантай холбогдуулан Moody's үнэлгээний компани "тогтвортой" буюу B1 зээлжих зэрэглэлд оруулах шийдвэрийг гаргасан байна.

Монгол Улс дэд бүтцээ хөгжүүлж, макро эдийн засгийн тогтвортой байдлаа хадгалж чадвал урт хугацаан дахь эдийн засгийн төлөв нь өөдрөг харагдаж байгааг тус агентлаг хэлж байна.

Зэрэглэлийг нэмэгдүүлэх хүчин зүйлс: Үнийн өсөлтийг тогтоон барих, валютын ханшийн тогтвортой байдлыг хадгалах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх зэрэг эдийн засагт эерэгээр нөлөөлөх арга хэмжээ багтана. Төсөв сангийн бодлого, дүрэм журмыг хэр өндөр түвшинд баримталж байгааг мөн чухлаар харгалзан үзнэ. Цаашлаад улсын орлого ба нийт экспортын хэмжээг нэмэгдүүлэхэд онцгой үүрэг бүхий цаг үеэ олсон дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд ач холбогдол өгнө. Түүнчлэн Монголын үйлдвэржилтийн суурь хөгжил, эдийн засгийн төрөлжилт нь уул уурхайн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлээс үүдэлтэй хэврэгшлээс хамгаалах бамбай болох учир томоохон хүчин зүйлд тооцох ажээ.

Зэрэглэлийг буруулах хүчин зүйлс: Инфляцийн өсөлт сэдэрч, валютын ханш тогтворгүйжин гадаад төлбөр тэнцлийг дордоход хүргэж болзошгүй байдал. Сангийн бодлогыг баримтлах ажлын хүрээнд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж чадалгүй зөрчих, хөрөнгө оруулалтын орчинд шинээр гарч ирсэн тодорхойгүй байдал, гадаадын өрийн хэмжээг хэтрүүлэн цаашид тэлсээр байх зэрэг нь зээлжих зэрэглэлийг бууруулах болзошгүй нөхцөлд орохыг Moody's сануулж байна.

Fitch үнэлгээний байгууллага Монгол Улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийг "B+" нэмэх буюу тогтвортой ангилалд хамгийн сүүлд багтаагаад байгаа юм. Энэ нь S&P- гийн үнэлгээнээс нэг шат доогуур үзүүлэлт юм. Харин манай улсын богино хугацааны төлбөрийн чадамж нь Fitch агентлагийн 'B' ангилалд орж байна. Тус байгууллага өнгөрсөн оны эцсээр гаргасан Азийн хөгжиж буй 12 орны талаарх тайландаа Шри Ланк болон Монголоос бусад орны гадаад валют давамгайлсан өр буурах хандлагатай байгааг мэдээлсэн билээ.

Монгол Улсын өмнө эдийн засгийн өөдрөг өнгө тодхон байна. Бялхам байгалийн баялагтай энэ улсын ДНБ-ий таван жилийн дундаж өсөлт нь 8.3 хувь байгаа нь тус улсын одоогоор багтаж буй 5.9 хувийн дундажтай тэнцэх "B" зэрэглэлээс давсан үзүүлэлт юм гэдгий тус агентлаг тооцжээ. Гэсэн ч 2011 оны байдлаар нэг хүнд ногдох орлогын хэмжээ 3056 ам.доллар байгаа нь "B" зэрэглэлийн дундаж үзүүлэлттэй эн зэрэгцэж байгаа ба цаашид эдийн засгийн хурдацтай хөгжлөө хадгалах шаардлагатай байгааг тэд зөвлөж байна. Харин засаглалын хувьд B зэрэглэлийн хүрээний улсуудтай зэрэгцүүлэхэд харьцангуй хүчтэйд тооцогдож байгаа аж. Нөгөө талаас уул уурхайн тэсрэлтээс үүдэлтэй макро эдийн засгийн эмзэг байдлыг багасгах нь хамгийн том сорилт хэвээр байгааг сануулав. Гэсэн ч дунд хугацааны эдийн засгийн хүчтэй өсөлтийн хандлага, Засгийн газрын өрийн хэмжээ бага, хүүгийн төлөлт нь тэдгээр сул талуудыг зөөллөх үндэслэл болж байгааг Fitch тайландаа дурьджээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг чандлан мөрдөж, гадаад эрсдэлээс хамгаалах бамбайг бий болгох нь таваарын үнийн хэлбэлзлээс төсвийг хамгаалахын зэрэгцээ Монгол Улсын гадаад санхүүжилтэд учрах дарамтыг багасгах, улмаар инфляцийг бууруулах хүчин зүйл болох учиртайг хэлж байна. Энэ нь мөн зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлэх талтай гэв. Харин эдийн засгийн чадамжыг бууруулсан төсөв сангийн тэлэлт тэргүүтэй бодлогын ухралт нь зээлжих зэрэглэл буурах бүрэн үндэслэл болно. Түүнчлэн Монголын банкны системд төр оролцож асар их хэмжээний дэмжлэг үзүүлэх нь үнэлгээнд сөргөөр нөлөөлөх том хүчин зүйл болохыг Fitch анхааруулаа.

ГУРВАН М

ЭРДЭНИЙН ЭЗЭД

Б. ҮҮРИЙНТУЯА

“Торгоны зам”-д хөтлөх эдгээр улсын эдийн засгийн өсөлтийн таамаг ирэх жилүүдэд хамгийн багадаа 10 хувь байна.

Байгаль эх баялгаараа эрхлүүлсэн гурван М улс гэхээр таны төсөөлөлд юу буухыг таашгүй. Гэвч дэлхийн эдийн засгийн тавцанд дээрх нэршил гагцхүү төв Азийн оргил болсон Монгол Улс, Африкийн өмнөд эргийн Мозамбик болон Зүүн өмнөд Азийн бадмараг нь гэх Мьянмар улсыг илтгэх ажээ.

“BRICS”-ийн орнуудын “энгэрийн чимэг” болж буй эл гурван улсын эдийн засгийн ахиц их гүрнүүдийн өсөлтийг хол хаяж, дэлхийн анхаарлын дуранг өөртөө чиглүүлээд багагүй хугацааг үдээд байна. Шинэ “Торгоны зам”-д хөтлөх эдгээр улсын эдийн засгийн өсөлтийн таамаг ирэх жилүүдэд хамгийн багадаа 10 хувь байхаар олон улсын шинжээчдийн мэргэн ухаанд буужээ. “Silk road management” олон улсын хөрөнгө оруулалт зохицуулагч байгууллагын тэргүүн Алишер Али “Зүүн өмнөд Ази, Африк болон Төв Азийн цээжинд орших Монгол Улсын асар их байгалийн баялгийн нөөц, хөгжиж буй эдийн засгуудын хөрш, ирэх арван жилд эдийн засгийн өсөлтөөрөө эхний тавд багтахуйц үзүүлэлттэй байгаа зэргийг үндэслэн “Silk Road M3” санг байгуулж буйгаа онцлон тэмдэглэе” хэмээн мэдэгдэж байсан нь саяхан. Сангийн гол зорилго дээрх гурван оронд үнэт цаасны арилжаа болон бусад үйл ажиллагаа эрхэлдэг олон улсын зах зээлд бүртгэлтэй байгууллагуудыг санхүүжүүлэх, дэмжихэд орших юм. Түүнчлэн улсуудын Засгийн газар дотоодын хөрөнгийн зах зээлийг дэмжин ажиллах нь олон улсын хөрөнгө оруулагчдын сонирхлыг өдөөж тус салбарт түлхүү оролцох хуслийг улам бадраана гэдгийг тус сангаас уламжилсан билээ.

S&P санхүүгийн компани өнгөрсөн сарын сүүлээр Монгол Улсын “тогтвортой” үнэлгээг шинэчилж, “эерэг” зэрэглэлд багтаалаа. Монголын уул уурхайн салбарт энэ жил үйлдвэрлэл тэлж эхлэх гэж байгаагаас үүдэн тус шийдвэрийг гаргаснаа мэдэгдсэн билээ.

Монголыг урт хугацаанд авч үзсэн зээлжих зэрэглэл нь BB- байгаа бол богино хугацаанд B үнэлгээтэй байна. S&P компанийн мэргэжилтнүүд Монголын нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт 2014 он хүртэл бодитоор өсөлт мэдрэгдэх 6500 гаруй ам.доллар болохоор хүлээгдэж байгаатай холбон тайлбарлалаа. Төсөв сангийн бодлого, гадаад өрийн хэмжээнд ахиц гарах эсэхээс хамааран Монголын зэрэглэлийг нэмэгдүүлэх боломж бий гэдгийг S&P мэдэгдэлдээ дурьдсан. Түүнчлэн мөнгө, сангийн болоод банкны салбарын бодлого зохицуулалтаар дамжуулан эдийн засгийн өртөмтгий хэсгүүд дэх эрсдэлийг бууруулах тал дээр гаргах дэвшлийг үндэслэн үнэлгээг харгалзах аж.

Харин банкны салбараас учирч болох цочмог хохирлыг хаасан, сангийн хөндлөнгөөс оролцох бодлого, төсвийн үрэлгэн тэлэлтээс үүдэн улсын нийт төсөв, макро эдийн засагт аюулын харанга дэлдэж эхэлбэл үнэлгээг одоогийн зэрэглэлд барих цаашлаад бууруулж болзошгүйг S&P мөн санууллаа. Гадаад өрийн хэмжээг цаашид тогтоон барилгүй алдах аваас Монголын дэлхийн зах зээлд тогтоож чадсан хүүгийн таатай хэмжээнд нөлөөлөх улмаар эргэн төлөх чадварт нөлөөлөн зэрэглэлийг мөн л адил бууруулах нөхцөл бүрдэх аюултай. Бодлогын үлбэгэр орчин, байгалийн баялагт суурилсан эдийн засаг Монголын үнэлгээнд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс болохоор байгааг S&P хэлж байна.



Хар алтны Могул

Зэс, алт болон газрын ховор элементээс гадна нүүрсний асар их нөөцтэй Монгол Улс дэлхийн уул уурхайн төвүүдийн нэг болоход тун ойр байна. Эдийн засгийн өсөлт нь олныг алмайруулах болсон Монголыг мэдэхгүй хөрөнгөтөн гэж үгүй болжээ. Арваадхан жилийн тэртээ Азийн хамгийн ядуу таван орны нэг гэж шоовдорлогдож байсан бол өдгөө нэг хүнд ногдох ДНБ 3000 ам.долларт хүрсэн гялалзсан амжилтаар хөгжлийн зүг хурдалсаар.

Зах зээлийн шинэ Маршрут

Ардчилал, шинэчлэлийн салхи үлээсэн тэр л цагаас санхүү, бизнесийн шинэ талбар болсон Мьянмарын эдийн засаг санхүүжилтээр “цангаж” байна. Дэлхийн бадмаараг чулууны хэрэглээний 90 хувийг хангадаг эл улс хэвлийдээ тээх эрдэнэсийн дээд сувд, саффир чулууны нийлүүлэлтээрээ ч алдартай. Газар нутгаараа тивдээ эхний хоёрт бичигдэх Мьянмарын 60 сая иргэн Азид төдийгүй дэлхийн хөдөлмөрийн зах зээлд (outsourcing) мөн бизнес, хөрөнгө оруулалтын асар их боломжийг бүрдүүлж байгааг олон нийт хэдийнэ мэдэх.





Аж үйлдвэрлэлийн Магнат

Дайны сүүдэрт дарлуулж ирсэн Мозамбикийн иргэд шинэ мянганы ололт, амжилтаар баялаг угтсан. 2001 оны эдийн засгийн өсөлтөө ДНБ-ий 14.1 хувийн үзүүлэлтээр тамгалж, аж үйлдвэрлэлийн ачаар жилийн дундаж өсөлтөө 10 хувьд барьж ирсэн нь хөгжилд тэмүүлэх тус улсын их зүтгэл дотоодын газар тариалан, харилцаа холбоо, аялал жуулчлалын салбарыг сөгийтөл нь өөд татаж байна. ■

Дэлхийн эдийн засаг



ДНБ-ЭЭС ГАДНАХ БАЯЛАГ

АЛЕКСАНДР ДИЛЛ, GLOBAL COMMONS INDEX

Хураангуй

Макро эдийн засгийн тусгал болсон тогтвортой байдал, эрсдэл, баялаг зэрэг үзүүлэлтүүд нь ДНБ-ий үндэс суурь болдог. Санхүүгийн хямрал, зээлийн эрэлт өсөж буйтай холбогдуулан Олон улсын валютын санд ирэх арван жилд нийт 10 их наяд ам.долларын улсын өр төвлөрүүлэх аж. Өрийн дээд хэмжээг тухайн улсын ДНБ, өр хоорондын харьцаагаар тодорхойлдог байна. ДНБ-ий тоон үзүүлэлт хэр үнэн, бодит байх нь улс төрийн хэмжээнд яригдах асуудал ч болох уе бий. 2007 онд болсон "ДНБ-ээс гадна" сэдэвт Европын холбооны хурлаар эдийн засгийн уламжлалт бус үндэслэлийг олох арга замыг ирэлхийлэхийг оролдож байсан ч тодорхой үр дүнд хүрээгүй билээ.

Энэхүү бүтээлийн эхний хэсэгт ДНБ-ийг бүрдүүлэгч хүчин зүйлс хэр бодит болохыг АНУ-ын ДНБ-тэй харьцуулан гаргаж ирэхийг зорьсон. Удаах хэсэгт ДНБ-д хамаарах олон улсын индексүүдийг тоон харьцуулсан үзүүлэлтээр жагсаасан болно. Гурав дахь хэсэгт тус үзүүлэлтийг боломжит хувилбараар орлуулах санааг дэвшүүлсэн. Үүнд Үндэсний нийт бүтээгдэхүүн гэх ойлголтын тусламжтайгаар "Дэлхий нийтийн хэрэглээний индекс" хэмээх шинэ ойлголтыг бий болгох юм. Үүнийг байгалийн, нийгмийн, хувийн болон олон нийтийн хэрэглээний бүтээгдэхүүн хэмээн ангилан эдийн засгийн шинэ үндэслэл болгох аж. Ингэснээр эдийн засаг валютын хэлбэлзэл, худалдаа болон улсын өр, зээлийн хэмжээнээс үл хамаарах боломж бүрдэнэ. Эцсийн зорилго нь гэвч дэлхийн эдийн засгийг илүү тогтвортой, бодит тоон үзүүлэлтээр хэмжихэд орших бөгөөд буурай орнуудыг одоогийн жагсаалтыг тэргүүлэгчдийг дагах бус харин өөрсдийн бүтээгдэхүүний чадамжаар улс орноо хөгжүүлэхэд уриалах юм.

1. Эдийн засгийг хуурах нь: АНУ, Европын холбоо яагаад ДНБ-ийг "аврах ажиллагаа"-нд орох болов

"Нью Йорк Таймс"-ийн 2009 оны наймдугаар сарын 27-ны дугаарт Нобелийн шагналт Лаурэтт Паул Кругман ДНБ-ий шинэ ирээдүйг танилцуулсан билээ. Түүний үзэж буйгаар АНУ-ын есөн их наяд ам.долларын нэмэлт өр их биш харин бүр бага



байгаа аж. Тэрбээр хэлэхдээ тус улсын Ерөнхийлөгч Обама улсынхаа эдийн засгийг дахин сэргээхийн тулд илүү их хөрөнгө зарах хэрэгтэй гэжээ. Тэгвэл дэлхийн санхүүгийн хямрал борооны дараах мөөг мэт олшрох өрийн данснаас улбаатай гэдэг нь ташаа ойлголт уу?

Өөрийн бүтээлдээ Кругман 2019 он гэхэд АНУ шинээр өр тавьсан ч тус улсын ДНБ, өрийн тоон харьцаа 70 хувиас илүү гарахгүй гэж үзсэн байна. Тэрбээр "Хэдийгээр Бельги (118 хувь) болон Итали улс (114 хувь) хамаагүй муу үзүүлэлттэй гарсан ч хоёр улсын аль нь ч санхүүгийн хямралд ороогүй" гэсэн юм. Түүний энэ онолыг АНУ-д хэрэгжүүлэх нь улсын тогтвортой байдалд хэт их эрсдэл авчирна гэж үзэж болох.


Хэрэв тус улсын ДНБ сүүлийн 10 гаруй жил тун тааруу үзүүлэлттэй байсан бол яах вэ? Эсвэл Америкийн ДНБ эдийн засгийн шинжлэх ухаанд суурилсан молиго байв уу? Өөрөөр хэлбэл, америкчууд эдийн засгийг хуурсан байх нь. Энэ бол сонсоход таатай зүйл биш. "Амьдралд таатай үнийн бүрдүүлэлт" нэртэй аргачлалын тусламжтайгаар Америкийн ДНБ-ий 80 гаруй хувийг тус улсын мэдээлэл, технологийн салбараас улбаатай ашиг бүрдүүлдэг байна. Энэ нь хэрэв 500 МВ – ын санах ойтой компьютерийг 1999 онд 500 ам.долларааp худалдаж байсан бол үүнийг 2009 онд мөн үнээр худалдаж авах боловч тус компьютерын хурдыг гурав дахин ихэсгэн таван GB-ийн санах ойтой болгосон байна гэсэн үг юм. Ийнхүү компьютер тус бүр 2500 ам.долларыг ДНБ-д оруулах аж.

Өрийн дансаа аривжуулсаар байгаа Америк улс Афганистан, Ирактай хийх дайнаа үргэлжлүүлж байгаа ч тус улсын ДНБ жил бүр гурван хувиар өсөж байна.

Жил бүр тус улсаас зэвсэгт хүчинд болон цэргийн үйл ажиллагаанд зарцуулах хэдэн их наяд ам.долларыг үл харгалзан Америк улсын эдийн засгийн брэндүүд болох General Motors, Apple, Adobe, Yellowstone Park зэрэг байгуллагуудад Америкийн ДНБ-ийг даатган үлдээвэл таагүй тоо гарах нь дамжиггүй. Үнэн хэрэгтээ Америк улс ДНБ-ийхээ 60 хувь биш 150 хувьтай тэнцэхүйц хэмжээний өртэй аж. Энэ нь тус улсын Хүний хөгжлийн индексийн үзүүлэлтэд таатай мэдээ биш юм. Хүний хөгжлийн индексийг тодорхойлогч нэг хүчин зүйл болох ДНБ бодит бус мэдээлэл агуулж байна гэдэг нь эргээд улсынхаа хөгжлийн индексийг хөлдөө чирдэг. Гэсэн хэдий ч Америкийн хувьд санаа зовох болоогүй байна. Учир нь, эдийн засгийг зөвхөн ДНБ-ээр хэмжихгүй гэх Кругманы энэ санаа бүсийн санхүүгийн хямралаас үүдэн өдийг хүртэл биелэлээ олоогүй л явна.

2009 оны наймдугаар сарын 20-нд гарсан мэдэгдэлд Европын Холбооны хэрэгжүүлэгч хороо одоогийн хэрэгжиж буй ДНБ-ий бодлогыг үргэлжлүүлэх ба Стиглиц Фитүссигийн хорооноос дэвшүүлсэн саналын дагуу нэмэлт, өөрчлөлт оруулна хэмээн зарласан билээ. Тэд дүгнэхдээ "2012 он гэхэд тус хороо нь бодлогын хэрэгжилт болон түүний үр дүнгийн талаар тодорхой тайлан гаргана" хэмээн онцолсон. Энэхүү дүгнэлт нь санхүүгийн хямрал гарахаас өмнө буюу 2007 онд хийж байсан мэдэгдэлтэй төстэй утга агуулж байгаа юм.

АНУ, Европын Холбоо ДНБ-ий бодлогодоо өөрчлөлт оруулахыг эрс



эсэргүйцэж буй шалгаан?

Ахин зээл авах түүнчлэн улсынхаа аюулгүй байдлыг алдахгүйн тулд Америк улсын “худал” ДНБ-ий тоон үзүүлэлтээ хадгалах хэрэг гарч байна. Цухасхан дурдахад АНУ-ын улсын баялгийн газрын 2008 оны арванхоёрдугаар сарын 31-ний мэдэгдэлд тус улсын нийт өрийн 40 хувь нь “Засгийн газар хоорондын Бонд” хэлбэрээр хуримтлагдсан гэжээ. Шударга байя. Зээлдэгч, зээлэгч хоёр адилхан. Тиймээс дараагийн арван жилийн хугацаанд дахин есөн тэрбум ам.долларын зээл авах нь асуудал биш. Харин бүх эдийн засагч худал өрийн хэмжээ, ДНБ-ий үзүүлэлтэд сохор мэт итгэх хэрэг байна уу?

Дэлхийн нийт өрийн 50 орчим хувь нь АНУ-д данстай байдаг. Дэлхийн хамгийн эртний банкуудын нэг болох Швейцарийн “Вегелин” банкны Ерөнхийлөгч Конрад Хамлерын үзэж буйгаар Америкийн ДНБ болон өрийн харьцаа 624 хувь гэдэг нь зүгээр нэг явган яриа биш аж. Тэрбээр 2009 онд Фрайбургийн Их Сургуулийн хийсэн судалгаанд үндэслэн дээрх дүгнэлтийг гаргажээ. Түүний хэлснээр хэрэв Америкийн ДНБ-ий үзүүлэлт хуурамч бол дэлхий дахин дахь тус улсын аюулгүй байдал хөөс болон замхарах аж.

Хэмжигдсэн болон хэмжигдээгүй ДНБ-ий ялгаа илүү бодит үр дүнд хүрэх алхмын нэгээхэн хэсэг болдог. Харин улсын өрийн ил болон далд шинж чанарыг гаргаж ирсэнээрээ Фрайбургийн судалгааны онцлог болсон юм. Ил өр гэдэг нь тухайн үед авсан бодит зээл бол далд өр нь хөгшчүүдийн тэтгэвэр, тэтгэмж зэрэгт олгох мөнгөн тусламж, түүнчлэн төрөлтийн хэмжээг багасгах зэрэг тухайн улсын хүлээх нийгмийн үүргүүдийг хамардаг.

Дэлхийн томоохон улсуудын өрийн хэмжээг графикаар харуулбал:

Улс	ДНБ дэх ил өр (хувь)	ДНБ дэх далд өр (хувь)
Швейцари	55,2	-155,0
Испани	35,4	80,8
Австри	62,8	242,7
Норвеги	40,6	291,3
Герман	62,5	315,1
Франц	60,4	315,3
Их Британи	37,2	567,2
АНУ	57,1	624,5

Эх сурвалж: Raffelhьschen, Bernd and others (2009), Ehrbare Staaten? Die deutsche Generationenbilanz im internationalen Vergleich, Stiftung Marktwirtschaft, Nr. 107, 2009 оны нэгдүгээр сар, хуудас 9

Графикт оруулсан мэдээллийг дэлхийн санхүүгийн хямралаас өмнө буюу 2004 онд гаргажээ. Тэгвэл эдгээр үзүүлэлт хямралын дараагаар, 2009 онд, улам дордсон нь тодорхой. АНУ-ын 2004 оны ДНБ-д амьдралд таатай үнийн бүрдүүлэлт (hedonic pricing), дайн болон яллагдагчид зэргийг оруулан тодорхойлсон учир бодит ДНБ дэх далд өрийн хэмжээ даруй 1000 хувьд хүрэх юм. Тиймээс тус улс энэ их өрийг буцаан төлөхгүй байх магадлалтай. Энэ тохиолдолд олон сөрөг үр дагаварыг даллах бөгөөд хамгийн их эрсдэлтэй нь инфляци юм. Америкийн хөрөнгийн биржийн томоохон хөрөнгө оруулагч Варрен Буффетт хэлэхдээ "Өр нь өөрөө санхүүгийн хямралтай дүйцэхүйц аюулыг дагуулна" гэжээ.

Дэлхийн ДНБ-ийг бүрдүүлэхэд хувийн болон хувьсгалын зарлагыг өр, зээлийн шугамаар санхүүжүүлдэг. Ингэснээр хэзээ нэг цагт эдийн засгийн өсөлт нь өрийн өсөлттэй ижил хэмжээнд хүрдэг байна. Энэ байдал удаан үргэлжлэх тохиолдолд өрийн өсөлт эдийн засгийн өсөлтийн үзүүлэлтийг давдаг. Энэ нь 200 их наяд ам.долларын өр байна гэж үзвэл үүнийг барагдуулахад нийт 160 валютаар нөөц 4 их наяд ам.доллар л байна гэсэн үг.

Олон улсын санхүүгийн сүлжээний мэргэжилтэн Дирк Солтэ "Санхүүгийн болон бодит хөрөнгийн хэмжээ дэлхийн ДНБ-ий үзүүлэлтээс давах үед мөнгөн хөрөнгө татварын нийт дүн бусад орлогоос хэд дахин их болдог" гэжээ. Үүний үр дүнд олон нийтийн орлого багасдаг байна. Эдгээр алдагдлыг Засгийн газрууд бонд гаргах замаар тогтворжуулдаг аж. Солтэ судалгаандаа өрийн хэмжээ олон нийтийн орлогын 100 хувьтай тэнцэх хэмжээнд хүрэх таамаг гаргасан.

Европын Холбооны хэрэгжүүлэгч хорооны 2009 онд хийсэн мэдэгдэлд "ДНБ-ий үзүүлэлт эдийн засгийн зах зээлийг тодорхойлох цорын ганц бөгөөд гол хэрэгсэл" гэсэн байдаг. Хамгийн том шалтгаан гэвэл Засгийн газруудыг өрөнд баригдаж өтөнд идэгдэхээс сэргийлэх мөн тэдний аюулгүй байдлыг хангахын тулд ДНБ болон өрийн харьцааг аргамжаалах шаардлага гэж болох. Хоёр дахь шалтгаан нь өсөлтийн урьдчилсан таамаг, ахиц болон үнийн хөөс, хямрал зэрэг нь бүгд ДНБ-д суурилдаг. Эдийн засгийн шинжлэх ухаан гэдэг нь өөрөө ДНБ-ий үзүүлэлтэд тулгууралдаг. Тиймээс ДНБ-ий бодлогыг шинэчлэн өөрчилнө гэдэг нь эйн засгийн шинжлэх ухааны үндэс суурийг орвонгоор нь өөрчилнө гэсэн үг.

2. Индексийн харьцуулсан үзүүлэлт- Дэлхийн үзүүлэлтийн өрөөсгөл хандлагыг хариулах нь

Даяарчлалыг дэмжигчдийн тоо томшгүй шүүмжлэлд хариу өгөх зорилгоор дэлхийн эдийн засгийн мониторингийн ойлголтод олон улсын шинэ үзүүлэлтүүд гарч ирсэн:

-The Human Development Index: Хүний хөгжлийн индекс гэх ойлголтыг НҮБ болон АНУ гаргаж ирсэн.

-The Environmental Stability Index: Байгаль орчны тогтвортой байдлын индексийг АНУ-ын Иелийн Их Сургуулиас гаргасан.

-The Happy Planet Index: Дэлхийн аз жаргалтай байдлын индексийг Лондон хотын "Шинэ эдийн засгийн сан"-гаас санаачилсан.

-The Living Planet report: "Дэлхийд амьдрах нь" тайланг Дэлхийн амьд байгалийн сан бэлтгэн гаргадаг.

Олон улсын үзүүлэлтийн гурван төрөл, үе шат байдаг гэж болно:

1. Хамгийн чухал бөгөөд зөвлөхүйц эдийн засгийн болон дэлхийн хөгжлийг тодорхойлогч үзүүлэлтийг заах тоон баримтууд. Тухайлбал, Дэлхийн банкнаас гаргадаг мэдээллүүд.

2. Боловсрол, аз жаргал, нийгмийн хөгжил, хүний эрхийг хамгаалах хууль зэргийг тодорхойлох үзүүлэлтүүд. Эдгээрийг илэрхийлэх тэргүүний индикаторыг Германы Бертелсманн сангаас гаргасан Бертелсманнын Transformation Atlas буюу Өөрчлөлтийн атласаар харуулдаг.

3. Бүсийн ажиглалт, био тархалт зэрэг байгаль, экологийн хэтийн төлөвийг харуулсан үзүүлэлтүүд.

Дээрх гурван ерөнхий индикатор дор бүрээ өөр өөр чиглэл, хамрах хүрээтэй. Гэсэн хэдий ч тэдгээрийн үйл ажиллагаа нягт холбоотой байдаг. Дээрх гурван үзүүлэлт бүгд шинжлэх ухааны бөгөөд соёлын үнэ цэнийг агуулдаг гэж болно.

Эдгээр олон улсын индикаторууд хэт өрөөсгөл үү?

Хүний хөгжлийн индекс гэх ойлголт түгсэн тэр л үеэс энэхүү үзүүлэлт аливаа улсын ДНБ-ий 86 хувьтай ижил хэмээн тодорхойлогдож байсан.

Индекс	Санаачлагч	Ач холбогдол Өртөг
Дэлхийн хөгжлийн үзүүлэлт Мэдээллийн сан/Улсын ангилал	Дэлхийн банк	+++++
Хүний хөгжлийн индекс	НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр	+++
Байгаль орчны тогтвортой байдлын индекс	Иелийн Их Сургууль, АНУ	+++
Дэлхийн аз жаргалтай байдлын мэдээллийн сан	Роттердамын Их Сургууль, Нидерландын Вант улс	++
Дэлхийн энхтайвны индекс	Австрали улсын энхтайвны сан	+
Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан	Дэлхийн эдийн засгийн форум	++
Үндэстнүүдийн хөрөнгийн тайлан	Дэлхийн банк	+++++
Далд эдийн засгийн индекс	Австрийн Линцийн Их Сургууль	+
Жил бүрийн Хөгжлийн үр нөлөө тайлан	Дэлхийн банк	+++
Дэлхийн үнэ, өртөгийн судалгаа	Стокхолмын Их Сургууль, Швед	++
Бертелсманнын өөрчлөлтийн атлас	Бертелсманн сан, Герман	++
Улсын стратегийн бичиг баримт	Европын Холбооны хэрэгжүүлэгч хороо	++++
Дэлхийн аз жаргалтай байдлын индекс	Шинэ эдийн засгийн сан, Лондон	+
"Дэлхийд амьдрах нь" тайлан	Дэлхийн амьд байгалийн хамгаалах сан	+++

Жишээлбэл, аль ч үзүүлэлтийг нь хэмжсэн Норвеги болон Швейцари улс харьцуулсан үзүүлэлтийн жагсаалтыг тэргүүлэх болно. Үүнээс үүдэн жагсаалтыг тодорхойлох хоёр шинэ аргачлал бий болж байгаа юм:

1. Индексийн харьцуулсан үзүүлэлт- Энэ нь аль нэг улсын бүх төрлийн индикаторыг хамран харьцуулах боломжийг олгосон.

2. Эс орших бүтээгдэхүүний араас шуурахын оронд гар дээр байгаа зүйлсдээ тулгуурлан индексийг бий болгох хэрэгтэй гэнэ. Ингэхийн тулд Дэлхийн нийтийн хэрэглээний индекс хэмээх ойлголтыг “нутагшуулжээ”.

3. Үндэсний нийт бүтээгдэхүүнийг бүтээх нь

Юуны өмнө эдийн засаг гэдэг ойлголтыг тайлбарлах нь зүйтэй. Эдийн засаг гэдэг нь олон нийтийн, иргэдийн болон хувийн өглөгийн тогтвортой харьцаа. Гэвч одоог хүртэл эдийн засаг хомсдолоор хязгаарлагдаж байгааг умартаж болохгүй. Иймд эдийн засгийн уламжлалт тодорхойлолтыг хөрөнгө, ажил эрхлэлт болон үндсэн хэрэглэгдэхүүний тэнцвэрт байдал хэмээн ойлгож болох нь. Энэ нь эдийн засгийн үндсэн бодролд эрс өөрчлөлтийг авчирч буй аж. Сүүлийн жилүүдэд “бүтээлч иргэд” гэх санаа тун эрэлттэй болсон. Дэлхийн зах зээлийг чөлөөт хөтөлбөр эзэлж эхэлсэн. Гэсэн ч дээрх нэр томъёо амжилт олоогүй юм.

Материаллаг бус бүтээгдэхүүн, үйлчилгээний үзүүлэлтийн тусламжтайгаар үүний мөн чанарыг тайлбарлавал:

Нийтийн хэрэглээ	Байгалийн хэрэглээ	Нийгмийн хэрэглээ	Хувийн хэрэглээ
Өндөр ач холбогдолтой	Түүхий эд, эрчим хүчний сэргээгдэх эх үүсвэр	Аюулгүй байдал, энхтайван, боловсрол	Хөлсгүй ажлын хүч, хар ажил
Дундаж ач холбогдолтой	Түүхий эд, эрчим хүчний хязгаарлагдмал сэргээгдэх эх үүсвэр	Хууль, эрх зүй, замын хөдөлгөөний мэдээлэл	Амьдралын аз жаргал, сэтгэл хангалуун байдал, шашин, соёлын өв
Дундаж ач холбогдолтой	Ундны ус, газар болон далайн гарц	Олон нийтийн байр суурь, чиг хандлага	Хүүхэд, төрөлт, наслалт

Уг индексийг боловсруулах явц шүүмжлэлтэй их тулгарсан. Өндөр ач холбогдолтой гэх категорид багтах жагсаалттай санал нийлэх нь олон байх ч хувийн болон субъектив эх үүсвэр болох шашин, энэрэнгүй үзэл, шударга ёс зэргийг ээдрээтэй асуудал хэмээн үзсэн. Эцэст нь хувийн гэх нэр томъёололд хувийн үзэл бодол орсон байх тул бүрэн тодорхойлох боломжгүй гэжээ. ■

Үр дүн: Үндэсний нийт бүтээгдэхүүнийг бүрдүүлэх нь

Ач холбогдол(хувь)	Нийтлэг хэрэглээний ангилал	Мэдээллийн сан/ томъёолол
Байгалийн хэрэглээ 25 хувь (байгалиас эхтэй, үнэ төлбөргүй бүтээгдэхүүн)	40 хувь сэргээгдэх эрчим хүч	Боломжит эрчим хүч
	20 хувь ус	Боломжит усны нөөц куб метр/жил
	20 хувь далай, эх газар	Нэг хүнд ногдох ам метр
	20 хувь боломжит сэргээгдэхгүй эх үүсвэрүүд	Зах зээлийн үнээр
Нийгмийн хэрэглээ 32 хувь (улс, орон нутгаас олгох үнэ төлбөргүй бүтээгдэхүүн)	20 хувь аюулгүй байдал, энхтайван	Дэлхийн энхтайвны индекс дэх байр
	20 хувь эрүүл мэнд 20 хувь боловсрол	Хүн амд ногдох үнэ төлбөргүй боловсрол, эрүүл мэндийн үзлэгт хамрагдах хувь
	15 хувь олон нийтийн газруудыг ашиглах боломж	Нэг хүнд ногдох ам метр
	10 хувь мэдээ, мэдээлэл	Хүн амд ногдох үнэгүй мэдээлэл, хууль, эрх зүйн орчин болон нийтийн тээврийн хувь
	10 хувь хууль, эрх зүйн орчин	
	5 хувь нийтийн тээвэр	
Хөлсгүй ажлын хүч, хар ажил 15 хувь	50 хувь төрийн болон олон нийтийн үйл ажиллагаанд зарцуулах цаг	Жилд зарцуулах нийт цаг
	50 хувь хувийн зорилгоор хөрш, найз нөхөд болон гэр бүлдээ зарцуулах цаг	Ижил түвшний үйл ажиллагаанд зарцуулах цагийг зах зээлийн хагшаар тооцох
Шашин, соёлын өв долоон хувь	50 хувь барилга, байгууламжид үнэ төлбөргүй нэвтрэх боломж	Хүн амын нийгмийн үйл ажиллагаанд үнэ төлбөргүй хамрагдах боломж
	50 хувь нийгмийн бүлэг, үйлчилгээнд үнэ төлбөргүй хамрагдах боломж	
Аз жаргал, сэтгэл хангалуун байдал долоон хувь		Дэлхийн аз жаргалын мэдээллийн сан
Хүүхдийн тоо долоон хувь		Төрөлт болон нийт хүн амын хэдэн хувь нь хүүхэд эсэх
Наслалт долоон хувь		Дундаж наслалт

ЕРТӨНЦ

НӨЛӨӨЛЛИЙН ГУРВАЛЖИН БУЮУ ОПС

Ж.ТҮМЭНБАЯР

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өнгөрсөн оны төгсгөлд дэлхийн хамгийн нөлөө бүхий хүмүүсийг нэрлэх үед дээрх гурван улстөрч тэрхүү жагсаалтын тэргүүн эгнээнд ямагт бичигдэж байсан.

Өргөн уудам нутагтай ч, геополитикийн хувьд зөвхөн хоёр том гүрэнтэй хиллэн орших манай орны улс төр, эдийн засаг бүхий л цаг үед хойд, өмнөд хөршөөсөө тодорхой хэмжээнд хамаарч, уялдан зохицсоор ирсэн. Харин ардчиллын эринээс хойш манай гадаад харилцаа дан ганц хөршүүдийн хүрээнээс хальж, эдийн засгаа эрчимтэй хөгжүүлэхийн тулд бидэнд бусад хөгжингүй орнууд, ялангуяа, АНУ, Япон, Герман зэрэг том гүрнүүдийн дэмжлэгийг авах зайлшгүй шаардлага үүссэн. Тэгвэл 2012 он манай улсад төдийгүй дэлхий дахинд үлэмж нөлөө бүхий гурван их гүрний хувьд ээлжит төрийн тэргүүнээ сонгох сонгуулийн жил байв. Манай улсын эдийн засгийн цаашдын хөгжилд тэдгээр улсын төр засгийн гадаад бодлого их бага хэмжээгээр нөлөөлөх нь тодорхой. Иймд дээрх гурван гүрний шинээр сонгогдсон төрийн тэргүүнүүдийн хувийн амьдрал, улс төрийн үзэл бариmтлал, чиг шугамын талаар бага ч болов мэдээлэл уншигчиддаа хүргэхийг зорилоо. ▸▸

Овог нэр: Барак Обама
Хашиж буй төрийн дээд албан тушаал: АНУ-ын Ерөнхийлөгч
Төрсөн огноо: 1961.08.04
Төрсөн газар: АНУ, Хавай муж, Хонолулу
Төгссөн сургууль: Колумбын Их Сургууль, Харвардын Хуулийн Сургууль
Мэргэжил: Эрхзүйч
Намын харъяалал: АНУ-ын Ардчилсан Нам
Шашин шүтлэг: Христийн шашин.
Гэр бүлийн байдал: Эхнэр,хоёр охин
Гарын үсэг:



Овог нэр: Владимир Владимирович Путин
Хашиж буй төрийн дээд албан тушаал: ОХУ-ын Ерөнхийлөгч
Төрсөн огноо: 1952.10.07
Төрсөн газар: ЗХУ-ын Ленинград хот /одоогийн ОХУ-ын Санкт-Петербург хот/
Төгссөн сургууль: Ленинградын УИС
Мэргэжил: ОУ-ын Эрхзүйч
Намын харъяалал: "Нэгдсэн Орос" Нам
Шашин шүтлэг: Оросын Үнэн алдартны шашин
Гэр бүлийн байдал: Эхнэр, хоёр охин
Гарын үсэг:



Овог нэр: Си Жиньпин
Хашиж буй төрийн дээд албан тушаал: БХКНТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга, Цэргийн зөвлөлийн дарга
Төрсөн огноо: 1953.06.15
Төрсөн газар: Хятад улс, Бээжин хот
Төгссөн сургууль: Цинг-хуа Их Сургууль
Мэргэжил: Химич, Улстөрч
Намын харъяалал: БНХАУ-ын Коммунист Нам
Шашин шүтлэг: Шашин шүтдэггүй
Гэр бүлийн байдал: Эхнэр, охин
Гарын үсэг:



Дотоод, гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгсэл, вэб дэх дээрх гурван эрхмийн талаарх мэдээллээс харахад эрх чөлөөний орны тэргүүн гэдгээрээ ч тэр үү, аль эсвэл өөр хоорондоо эрс ялгаатай соёл, зан заншлын хослолын биет загвар болдгоороо ч тэр үү АНУ-ын +ерөнхийлөгчийн талаарх, ялангуяа хувь хүнийх нь талаарх мэдээлэл нөгөө хоёрынхтой нь харьцуулахад илүү нээлттэй, ил тодоор нийтэд цацагддаг нь түүний бас нэг давуу тал, ард иргэдийнхээ дунд итгэл хүлээх чухал түлхүүр гэлтэй. Ганц жишээ дурдахад Обама өөрийн сайтаа ямар нэг нууцлалгүйгээр barackobama.com гэж зарласан байхад нөгөө хоёр нь энэ тухайд "албаны сайт" гэсэн үгээр халхавчлан нууцлаг үлдэхийг илүүд үздэг бололтой. Томоохон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өнгөрсөн оны төгсгөлд дэлхийн хамгийн нөлөө бүхий хүмүүсийг нэрлэх үед дээрх гурван улстөрч тэрхүү жагсаалтын тэргүүн эгнээнд ямагт бичигдэж байсан нь тэд дэлхийн бодлогыг тодорхойлогчдын тоонд зүй ёсоор багтаж буйг ахин дахин нотлон харуулсан. Тухайлбал, өнгөрсөн арваннэгдүгээр сард АНУ-ын ерөнхийлөгчөөр дахин сонгогдсоных нь дараа "Тайм" сэтгүүл Б.Обамаг хоёр дахь удаагаа "Оны хүн"-ээр тодруулсан ба сэтгүүлийн ерөнхий эрхлэгч Ричард Стенгель бичихдээ: "Бид соёлын болоод хүн ам зүйн түүхэн өөрчлөлтийн цаг үед амьдарч байгаа бол ерөнхийлөгч Обама энэхүү шинэ Америкийн бэлэг тэмдэг төдийгүй, зарим талаараа түүнийг бүтээгч юм. Ерөнхийлөгчийг бид цоо шинэ олонхийг бүрдүүлж буй болгох; сул талыг давуу тал руу хувиргах, өнөөгийн асар их саад бэрхшээлийг даван туулж илүү төгс төгөлдөр нэгдсэн улсыг байгуулах "Оны хүн"-ээр тодруулж буй хэрэг" гэжээ.



АНУ-ын 44 дэх ерөнхийлөгч Б.Обама нь энэ өндөр сэнтийд заларсан африк гаралтай анхны хүн.

Обамагийн ээж Стэнли Энн Дунхам Канзаст төрсөн цэвэр англи бүсгүй бол аав том Барак Обама нь Кени нутгийн уугуул жинхэнэ африк нэгэн байжээ. Хосууд 1960 онд Хавайн Их сургуульд сурч байхдаа танилцаж, 1961 онд гэрлэсэн авч тухайн жилийн намар Стэнли Вашингтонд суралцахаар хүүгийн хамт Сиэтл рүү түр шилжсэнээр амьдралынх нь зам салаалжээ. 1964 онд тэд гэрлэлтээ албан ёсоор цуцлуулсны дараа эцэг Обама Кени руугаа буцаж, тэнд нутгийн бүсгүйтэй дахин гэрлэсэн аж. Тэрбээр 1971 онд хүү Барриг Хавайд байхад зөвхөн ганц удаа ирж уулзсан ба сүүлд 1982 онд автын ослоор нас баржээ. "Аав маань миний ойр дотны хүмүүсээс тэс өөр, яг л давирхай шиг тас хар байхад ээж яг л сүү шиг цав цагаахан харагддаг байсан нь гэнэн насны минь ой тойнд бүдэг бадаг үлджээ" гэж Обама бага насны дурсамждаа ярьсан байдаг. 1963 онд эх Дунхам Хавайн Их»



Цагаан Ордны “Ногоон танхим”-д гэр бүлийн хамт. 2009

сургуулийн оюутан Лоло Соеторо гэгч Индонези залуутай танилцаж, 1965 оны эхээр байгалийн үзэсгэлэнт Молокай арал дээр хуримлажээ. 1966 онд Лоло нутаг руугаа буцаж, жил хагасын дараа эхнэр нь дагавар хүүгийн хамт хойноос нь очсоноор тэд Жакарта хотын нэг ядмагхан дүүрэгт төвхнөсөн аж. Гэхдээ хоёр жилийн дараа тэднийх хотын төвийн харьцангуй тансаг Ментенг дүүрэг рүү шилжинсуурьшжээ. Зургаагаас арав хүртлээ, Обама индонези сургуульд сурч, 1971 онд өвөө, эмээтэйгээ амьдрахаар Хонолулу руу буцсан ба 1979 онд дунд сургуулиа төгсөх хүртэл тэнд амьдарч байв. Эдгээр он жилүүдийн тухай Обама хэзээ хойно дурсахдаа: “Хонолулуд амьдарч байхдаа өөр хоорондоо тэс ондоо соёл, зан заншил харилцан биесээ хүндэтгэсэн тааламжтай уур амьсгалд зэрэгцэн оршиж болдгийг бие, сэтгэлээрээ мэдрэх ховорхон боломж олдсон нь миний ертөнцийг үзэх үзэл төлөвшихөд онцгой нөлөөлж, хамгаас эрхэмлэдэг үнэт зүйлсийн минь үндэс нь болсон гэж боддог” гэжээ.

Түүнчлэн өсвөр насандаа тархинд нь байнга эргэлдэх “Ингэхэд би хэн юм бэ” гэсэн асуултыг үлдэн хөөхийн тулд үе үе найзуудтайгаа нийлж согтууруулах ундаа хэрэглэж, марихуан, кокайн татдаг байснаа ч тэрбээр нуугаагүй. Ийн мансууруулах бодистой нөхөрлөж байсандаа маш их харамсаж буйгаа хожим нь, 2008 оны сонгуулийн кампанийнхаа үеэр олон нийтийн өмнө илэрхийлсэн. 1972-75 онд, ээж нь Хавайд ирсэн үед Обама ээж, охин дүү хоёртойгоо амьдарч байгаад тэднийг Индонези руу буцахад Хавайдаа үлджээ. Тэр цагаас хойш хориод жилийг Индонезид өнгөрүүлэхдээ эх нь 1980 онд Лологоос салж, 1992 онд хүн судлалаар докторын зэрэг хамгаалсан боловч харамсалтай нь савны хорт хавдраар өвчилж, Хавайд ирж эмчлүүлж байгаад 1995 онд таалал төгсчээ. Обама эцгийнхээ эх оронд анх 1988 онд сар гаруй хугацаагаар аялж, аавын талын олон ах дүүстэйгээ уулзаж, танилцсан бол түүнээс хойш 1992 онд сүйт бүсгүй Мишелийн хамт, дараа нь 2006 онд аавынх нь унасан газар, угаасан ус болох Кенийн баруун хэсэгт буй жижигхэн тосгоныг тусгайлан зорьж очиж байжээ.

1989 оны зургадугаар сард Чикагогийн Сидлей Аустин хуулийн компанид туслах ажилтнаар ажиллаж байхдаа эхнэр Мишель Робинсонтой анх танилцсан. Тэр үед Мишелийг компаниас нь гурван сарын хугацаагаар Обамагийн зөвлөхөөр томилсон байсан ба Обамагийн зүгээс болзох тухай хүсэлт тавихад эхэндээ шууд няцаадаг байжээ. Гэвч зуны эцэс гэхэд тэд болзож эхлээд, 1991 онд сүй тавьж, 1992 оны аравдугаар сарын 3-нд гэр бүл болсон. Том охин Малиа Энн нь 1998 оны долдугаар сарын 4-нд буюу АНУ-ын Улс тунхагласны баярын өдөр төрсөн нь бас ч нэгийг хэлэх шиг. Харин удаахь Наташа нь 2001 оны зургадугаар сарын 10-нд төржээ.



Обама охин дүү Мая Соеторо , эзж Энн Дунхам,ввөө Стэнли Дунхам нарын хамт, Хонолулу, Хавай

Тэднийх Бо хэмээх усанд шумбагч португали үүлдрийн нохойтой. Түүнийг сенатор Тэд Кеннеди бэлэглэсэн.

2006 онд өгсөн нэгэн ярилцлагадаа Обама: “Манайх яг л Мини-АНУ гэсэн үг. Надад хар арьст эстрадын алиалагч Берни Мактай, эсвэл төмөр хатагтай Маргарет Тэтчертэй төстэй хамаатан садан аль аль нь бий” хэмээн хошигносон нь бий. Тэрбээр эх нэгт охин дүү Маяатайгаа хамт шахуу өссөн бол түүнд эцэг нэгтэй долоон ах, дүү бий /зургаа нь амьд мэнд байгаа/. Ирландад ч бас түүний үеэлүүд буй. Обамагийн эмээ Мэдлин Дунхам 2008 оны арваннэгдүгээр сарын 2-нд, зээ хүүгийнхээ их гүрний ерөнхийлөгч болохыг хараахан үзэж чадалгүй, хоёрхон хоногийн өмнө бурхан болсон нь харамсалтай. Эхийн талын холын уг гарвал нь иргэний дайны үед Америкийн холбооны улсуудын ерөнхийлөгч асан Жефферсон Дэвистэй хамаатай байж болох талаар тэрбээр нэгэнтээ бичжээ.

Обама эх хэлнээсээ гадна бага ахуйдаа дөрвөн жил Жакартад байхдаа сурсан индонези хэлтэй. Саг сайн тоглодог, солгой дохилттой.

Хувийн асуудлыг шийдвэрлэсэн нь: Обама тамхи их татдаг байсан ба тамхиа хаях гэж хэд хэдэн удаа оролдож, тэр ч бүү хэл, никотин орлуулах эмчилгээ хийлгэж байсан. Эцсийн дүнд 2010 оны эхээр тэрбээр уг муу зуршлаасаа маш амжилттай салж чаджээ.

Гэр бүлийн хөрөнгө, орлого: 2005 онд Обамагийнх Чикагогийн Хайд Парк дахь орон сууцнаасаа Кенвуд дүүрэгт орших 1.6 сая ам.долларын үнэтэй хувийн байшинд нүүж орсон. 2007 оны арванхоёрдугаар сард "Money" сэтгүүлээс хийсэн судалгаагаар тэдний гэр бүлийн жилийн цэвэр ашгийг ойролцоогоор 1.3 сая ам.доллар гэж тооцоолжээ. Өөрөөр хэлбэл, 2005 онд 1.6 сая байсан гэр бүлийн орлого нь 2007 онд 4.2 сая болж өссөн аж. 2009 оны татвар төлөлтийн дүнгээс харахад ихэнхдээ Обамагийн номын борлуулалтаас олох дээрх орлого 5.5 сая болж өссөн тооцоо гарчээ.

Буяны үйл ажиллагаа:Ерөнхийлөгч Обама 2010 оны 1.7 саяын орлогоосоо 14 хувийг нь ашгийн бус байгууллагуудад, тухайлбал дайнд шархадсан ахмад дайчдад чиглэсэн буяны үйл ажиллагаа явуулдаг Фишер ХаусСанд л гэхэд 131000 ам. доллар хандивласан байна. Урьдчилсан тооцоогоор ерөнхийлөгчийн 2012 оны орлогын мэдүүлэгт түүний орлого 10 саяд хүрнэ гэж мэргэжилтнүүд таамаглаж байна.

Улс төрийн замнал: Дунд сургуулиа төгсөөд 1979 онд Өрнөдийн коллежид суралцахаар Лос Анжелес явж, 1981 оны хоёрдугаар сард тухайн үед их сургууль, коллежийн оюутнуудын дунд өргөн хүрээтэй өрнөж байсан Өмнөд Африк дахь арьс өнгөөр ялгаварлах үзлийг эсэргүүцсэн хөдөлгөөний хүрээнд “Өмнөд Африкаас хөрөнгө оруулалтаа татах”-ыг уриалсан нь түүний хувьд нийтийн өмнө үг хэлсэн анхны тохиолдол байв. 1981 оны сүүлчээр Обама Нью-Иорк дахь Колумбийн Их сургуулийн улс төр судлалын ангид элсэж, олон улсын харилцаагаар мэргэшин 1983 онд бакалавр зэрэгтэй төгссөн. Түүнээс хойш олон улсын Бизнесийн корпораци, Нью-Иоркийн Олон нийтийн эрх ашиг судлалын байгууллага, Девелопинг Коммюнитиес төсөл, Гамалиел сан зэрэг хөгжиж буй орнууд дахь ядуурал, ажилгүйдэл, хүчирхийлэл, боловсролын хоцрогдлын асуудлыг шийдвэрлэх зорилготой янз бүрийн сан, шашны байгууллагад зохион байгуулагч, зааварлагч, зөвлөхөөр ажилласан. 1988 оны сүүлчээр тэрбээр Харвардын Хуулийн сургуульд элсэн суралцсан. Обама 2004 онд Иллинойс мужаас АНУ-ын сенатад нэр дэвших эрхтэй болж, кампаниа эхлүүлэн арваннэгдүгээр сард сонгуульд ялж сенатор болсон үеэс олон нийтийн анхааралд өртөж эхэлжээ. Өмнө нь 1992-2004 онуудад Чикаго хотод иргэний эрхзүйн өмгөөлөгчөөр ажиллахын зэрэгцээ Чикагогийн Их сургуулийн Хуулийн сургуульд үндсэн хуулийн эрх зүйгээр багшилж байсан аж. Ерөнхийлөгчийн сонгуулийн кампаниа 2007 онд эхэлж, 2008 онд анхан шатны сонгуульд Хиллари Клинтонг ялснаар Ардчилсан намаас АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших эрхтэй болж, улмаар БНН-аас нэр дэвшигч Жон МакКейнийг ялснаар 2009 оны нэгдүгээр сарын хоринд ерөнхийлөгчийн албан тушаалаа албан ёсоор хүлээн авсан. Мөн оны аравдугаар сарын 9-нд Норвегийн Нобелийн шагнал олгох хороо “Олон улсын дипломат харилцаа, ард түмнүүдийн хамтын

ажиллагааг бэхжүүлэхэд онцгой хүчин чармайлт гаргасан тул” Обамаг “2009 оны Нобелийн Энхтайвны шагналтан”-аар зарлаж, Осло хотноо шагналыг гардуулснаар тэрбээр уг шагналыг хүртсэн АНУ-ын дөрөв дэх ерөнхийлөгчөөр, ерөнхийлөгчийн албаа хашиж байх үедээ шагнагдсан гурав дахь хүнээр тодорчээ.

Гадаад бодлогын чиг шугам

Дэлхийн улс төрийн бодлогын шинэ нөхцөлд АНУ Ази-Номхон далайн бүс нутаг руу илүү анхаарал хандуулж байна. Энэ нь Иракийн дайны төгсгөл, 2014 он гэхэд Афганаас бүх цэргээ эргүүлэн татах амлалт зэргээс илт харагдаж буй.Өнгөрсөн сонгуулийн мөрийн хөтөлбөртөө олон улс дахь цэргийн ажиллагаагаа хязгаарлах талаар тусгасан нь нэг талаас Америк, Европыг хамарсан эдийн засгийн хямралын улмаас цэргийн зардлаа бууруулах бодлоготой холбоотой ч нөгөө талаас харь улс орнуудад явуулж буй учир утгагүй дайнд үр хүүхэд, хань ижлээ алдахаараа нэг болсон америк эмэгтэйчүүдийн шахалт шаардлагын тусгал байв. Иймээс ч дээрх санаачилга өнгөрсөн жилийн сонгуульд ялахад нь тодорхой хэмжээгээр түлхэц болж өгсөн. Монгол Улсын зүгээс АНУ-ыг “гурав дахь хөрш”-өө хэмээн тодорхойлсонд маш их сэтгэл хангалуун байдгаа хоёр улсын төрийн дээд түвшний уулзалт бүрийн үеэр ноён Обама удаа дараа хэлж, Монголыг, Монголын ардчиллыг дэмжиж буйгаа байнга илэрхийлж ирсэн. Яг энэ үзэл санаагаараа АНУ-ын ерөнхийлөгч, түүний засаг төр Монгол улстай ирэх дөрвөн жилийн хугацаанд харилцана гэдэгт монголчууд бид итгэлтэй байгаа. ■

Үргэлжлэл бий



Цагаан Ордны сагсан бөмбөгийн талбайд. 2009

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ



Б.ЭНХ

Энэ бол ерөөсөө л олон улсын сангууд, компаниудыг авчирч тэдэнтэй хамтарч ажиллаж, тогтоон барьж улмаар хурдтай гэвч тэсвэртэй стратегийн зөв төлөвлөлт бүхий арга замаар урагш ахих тухай л асуудал юм.

ӨӨРЧЛӨЛТӨӨС, ӨӨР ОРНЫ ТҮНШҮҮДЭЭС БҮҮ АЙ

Дэвид Лэстэр нь 2001 онд Лондоны хөрөнгийн бирж группын гэр бүлд ам бүл нэмсэн бөгөөд одоогоор тус группын стратегийн голлох санаачилгуудыг дэмжих, хэрэгжүүлэх үүрэг бүхий Стратеги хариуцсан захирлаар ажиллаж байна. ЛХБ хэмээх их айлын хаалгыг татахаас өмнөх 23 жилийн хугацаанд тэрбээр “Thomson Financial”, “Accenture” болон “KPMG” тэргүүтэй томоохон байгууллагад санхүүгийн мэдээллэл, технологийн чиглэлээр ажиллаж байсан арвин туршлагатай нэгэн. Монголын Засгийн газар болон Лондоны хөрөнгийн бирж хооронд үзэглэсэн” хамтын ажиллагааны “Мастер гэрээний хүрээнд МХБ-д суурилуулсан Миллениум IT системийг албан ёсоор хүлээн авах ёслол өнгөрсөн сарын 19-нд болсон билээ. ЛХБ-ийг төлөвлөн тус арга хэмжээнд оролцохоор Монголд ирсэн Давидтэй “Mongolian Economy” сэтгүүл ярилцсаныг хүргэж байна. ▸▸



Фотог Зохиогч

-Нэн тэргүүнд яагаад Лондоны хөрөнгийн бирж таны ажиллах талбар, Монголын түнш байх ёстой вэ гэж асуумаар байна?

-Гурван жилийн хугацаатай түншлэлийн гэрээг 2011 онд байгуулсан байгаа. Бидний хамтын ажиллагааг эхлүүлсэн гэрээ цаашид ч олон жил үргэлжилнэ гэж итгэж байна.

Дэлхийд тэргүүлэгч технологийг суурилуулах, олон улсын хөрөнгийн зах зээлтэй нэгтгэх, дэлхийн брокерууд Монголын зах зээлтэй шууд холбогдох арга замыг нээх, улмаар хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, илүү олон компани Монголд хөрөнгө босгодог болох, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн индексүүдтэй болгох, таваарын бүтээгдэхүүний арилжааг бий болгох, үнэт цаасны мөнгөн төлбөр тооцооны клиринг хаустай болох зэрэг нь нь стратегийн 5-10 жилийн хугацааны төлөвлөгөөнд тусгагдах ажлын үйл явц юм. Энэ бүгдийг амжилт болгон хувиргахад хийх зүйл их байна. Өнөөдөр бид зөвхөн технологийн шинэчлэчлэл хийгээд байна.

Хэрэв санхүүгийн хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх хүсэлтэй байгаа Монголын хувьд салбартаа гаршсан Лондоны хөрөнгийн бирж шилдэг түнш байж чадна. Учир нь, дэлхийн санхүүгийн тэргүүлэх төв нь ЛХБ. Түүнчлэн санхүүгийн зах зээлийн томоохон тоглогчид бүгд манай үйлчлүүлэгчид байдаг. Гадаад валютын арилжаа, тогтсон хугацаа болон хүүгийн хэмжээ бүхий санхүүгийн хэрэгслээр ЛХБ мөн л дэлхийд манлайлдаг. Тиймээс бидэнд Монголд хөрөнгийн зах зээлийг амжилттай босгож ирэх нөөц, чадамж нь бий.

-Та Монголын Засгийн газар олон улсын зах зээлээс босгосон 1.5 тэрбум ам.долларын бондын талаар юу хэлэх вэ ?


-Хөрөнгийн зах зээл Монголын бондыг таатай хүлээж авсан гэдэг нь маргаангүй үнэн. Чингис бондын зах зээлийн хандлагаас харахад маш том амжилт байлаа. Монголын хувьд дэлхийн зах зээлд өөрсдийгөө таниулж чадсан энэ боломжоо ухаалаг ашиглах хэрэгтэй. Ингэж чадвал дээрх мөнгө хөрөнгө оруулалт болж улмаар илүү их мөнгө босгох, 2021 он хүртэлх стратегийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилгод хүрэх гүүр болох учиртай.

-Одоогоор бондын мөнгөнөөс хөрөнгө оруулалт хийж болох төслүүдийг Засгийн газар нэгтгээд явж байна. Мөнгөний зарцуулалтаа тооцоолсон нарийн төлөвлөөгүй атлаа бонд гаргачихсан нь Засгийн газрын хувьд алдаа байсан гэж Та бодож байна уу?

Төмөр зам, тээвэр зэрэг санхүүжилтэд хүлэгдсэн хангалттай олон төсөл байгаа гэж ойлгож байгаа. Тухайлбал, аж үйлдвэрийн парк байна.

Нэгдүгээрт, ямар төслүүд байх нь Ерөнхий сайдын мэдлийн асуудал. Хоёрдугаарт, Бондын хувьд илэрхий том амжилт үзүүлсэн нь үнэн. Олон улсын хөрөнгө оруулагчдад бондын мөнгөн дүнд таарсан хангалттай төсөл байгаа гэдгийг Засгийн газрын зүгээс нарийн тайлагнасан. Тэгэхээр хөрөнгө оруулагчид энэ мөнгө хаашаа явахыг харсан, цэнэсэн учир худалдаж авсан.

Монголчууд анхны удаагийнх атлаа өндөр амжилт гаргасанд талархан хүлээж авч, баярлах хэрэгтэй. Харин одоо энэ мөнгө хэрхэн хөрөнгө оруулалт болж хувирахыг харах үлдлээ. Гаднынхан Монгол цаашид хэрхэн хөгжихийг харж байгаа.



Олон улсын санхүүгийн төв Лондоноос тус бондын мөнгөний 66 хувь нь орж ирсэн. Лондон мөнгө юунд зарцуулагдах, сайн хөрөнгө оруулалт болж чадах эсэх, өндөр ашиг хүртэх эсэхийг тооцдог мэргэжлийн баг, арга барилтай. Өнөөдөр бид үндсэн мөнгөн дүнгээс 10 дахин давсан захиалгатай, доогуур хүү бүхий 1.5 тэрбум ам.долларын бондтой сууж байна. Энэ нь хөрөнгө оруулагчид, арилжаалагчид хоёул олон хүчин зүйлийг өмнө нь тооцож үзсэн гэсэн үг. Тиймээс үр дүн нь ингэж гарч байгаа.

-Монгол Улс хүссэн, хүсээгүй дэлхий нийтийн асуудлаас нягт хамааралтай болчихлоо. Тэгвэл эдийн засгийн давагдашгүй ямар эрсдэлүүдээс болгоомжлох зайлшгүй шаардлага бидэнд тулж байна вэ? Хэрхэн бэлдэх вэ?

Төлөвлөгөөтэй байхын зэрэгцээ итгэхүйц олон улсын түншүүдтэй байх хэрэгтэй. Бүгд л ашигт малтмалын олборлолт, боломжууд эхлэл үедээ явж байгааг харж байна. Хэрэв энэ бүхнийг сайн бодож төлөвлөн хийвэл, Монголын хувьд зорилгодоо хүрч чадна. Энэ бол ерөөсөө л олон улсын сангууд, компаниудыг авчирч тэдэнтэй хамтарч ажиллах, тогтоон барьж улмаар хурдтай гэвч тэсвэртэй стратегийн зөв төлөвлөлт бүхий арга замаар урагш ахих тухай асуудал.

Монгол Улсад боломж их байна. Тухайлбал, Монголын хүн амын дийлэнх нь 20 гаруй насны хийж бүтээх үе дээрээ яваа залуус. Мөн хүн ам цөөн учир тэдэнд оногдож буй боломж ч тэр чинээгээр асар их байгаа нь гайхалтай.

Өөрчлөлтөөс мөн өөр орны түншүүдээс бүү эмээ. Гар нийлэх олон улсын хөрөнгө оруулагч, хамтрагчдаа сөрөг талаас нь, хардлагын нүдээр түрүүлж битгий хар. Хамтрагчаа сайн судалж сонго тэгээд хамтдаа бүтээ. Манайх шиг 200 жилийн настай байгууллагуудын амжилт, туршлагыг сайн суралцаж, өөрдийн болгох хэрэгтэй.

Тухайлбал, “FTSE индекс тооцооллын байгууллагын Лондонд бүртгэлтэй уул уурхайн компаниудын зах зээлийн үнэлгээ нь 500 гаруй тэрбум ам.доллартай тэнцдэг. Лондоны хувьд энэ амжилтад хүрэхийн тулд 30-40 жил шаардсан. Хөндлөнгөөс харж буй хүний хувьд, монголчуудаас хийж бүтээх хүсэл зориг, өөрчлөлтийг хүлээн авч тогтоон барих, боломжийг хүлээх бус өөрсдөөө бий болгох цаашлаад зөв зүгт хурдтайгаар залах тэмүүлэл буцалж буйг харж байна. Богино хугацаанд үүнийг хийж болох ч сайтар бодож төлөвлөсөн, хэврэг бус аргаар урагшлах ёстойг ямагт санах хэрэгтэй.

-Та өнөөгийн Монголын хөрөнгийн биржийн үйл ажиллагаанд ямар дүн тавих вэ?

-Дэлхийн санхүүгийн тэргүүлэх төвийн үйл ажиллагааг авч явдаг системийг Монгол зах зээлдээ суурилуулсан. Харин одоо тус системийн чадлыг гаргахын тулд дэлхийн зах зээлүүдтэй нэгтгэх хэрэгтэй. Тухайлбал, Монголын үнэт цаасны хадгаламжийн төвтэй дэлхийн аль ч хадгаламжийн төв холбогдох шаардлагатай байна. Түүнчлэн кастадион банкуудын хувьд дээрх хадгаламжийн төвтэй холбогдож, мөнгөн төлбөр тооцоог гүйцэтгэж чаддаг болох нь чухал байна. Ингэснээр Лондон, Нью Йорк эсвэл Японд амьдарч буй хэн ч Монголын үнэт цаасыг эзэмшиж, түүндээ санаа зовнидоггүй болно.

Монгол Улсыг FTSE индексийн хөгжиж буй зах зээлд буюу “Frontiers Market” зэрэглэлд багтаасан байгаа. Ингэснээр Монголын зах зээл чадавхжаад ирэхээр FTSE Монголын индекс бүтээгдэхүүнийг хүмүүс худалдан авах боломж нээгдэх юм. Цаашлаад олон янзын индекстэй болоод ирэхээр тасралтгүй идэвхтэй эргэлт бий болдог. FTSE хүмүүс хөрөнгө оруулахыг хүсдэг сан бий болгодог. Хэрэв харилцагчид зэс эсвэл нүүрсний компани сонгомооргүй байвал индекст хөрөнгө оруулж бас болно. Хөрөнгө оруулж болох индекстэй болмогц үнэт цаасны үүсмэл зах зэрэг боломжууд



дагаад гарч ирдэг.

-Монголын хөрөнгийн биржийн шинэчлэлтэй холбоотой таагүй мэдээ гарч амжсан. Тухайлбал, МХБ ТОР 20 индексийн огцом уналтыг шинэ системтэй холбож үзэх хүн цөөнгүй. Энэ мэт системтэй холбоотой дуулианыг юу гэж тайлбарлах вэ?

-Зах зээл өсөж бас буурч л байдаг. Жам нь иймээс хойш системтэй холбох ямар ч үндэслэл байхгүй. Монголын хөрөнгийн бирж дэх үнэт цааснууд, эрэлт, нийлүүлэлттэй л холбоотой асуудал. Өнөөдөр индекс шинэ үнэлгээтэй байлаа гэхэд маргааш бас ирээдүйд ч өөрчлөгдөж болно. Систем индексийн үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйл биш.

-Хөрөнгийн биржийн арилжааны идэвхи сул байна. Өнөөгийн нөхцөлд хэрхэн сайжруулж болох вэ?

-Энэ бол бидний түншлэлийн дараагийн алхам. Лондон олон улсын санхүүгийн банк, хөрөнгө оруулагчдыг Монголд авчирч зах зээлийн хөрвөх чадварыг гүнзгийрүүлж чадах болов уу?, Бид “Morgan Stanley”, “UBS”, “Goldman Sachs” тэргүүтэй акулуудыг Монголын хөрөнгийн биржийн оролцогчид болгож, хөрвөх чадварыг сайжруулж чадах уу гэж үү.

Хөрвөх чадвар сайжраад ирэхээр хэт тогтворгүй, хувирамтгай чанар үлэмж хэмжээнд үзэгдэхээ больдог. Өөрөөр хэлбэл, зах зээл огцом өсөж, уруудахаа болино гэсэн үг. Түншлэлийн хүрээнд бид дэлхийн санхүүгийн зах зээлүүдийг холбосон өөрсдийн системтэйгээ Монголынхыг холбох гэж байна. Энэ нь дээрх банкуудад Монголд арилжаа явуулах замыг нээж өгнө гэсэн үг. Томоохон банкуудын анхаарал Монгол руу татагдаж, эхнээсээ салбараа нээж шууд хөрөнгө оруулалт хийх, зах зээлийн шууд оролцогч болох хөшүүрэг нь болно. Ирээдүйд Нью Йорк, Лондонд бус Монголын хөрөнгийн биржид компаниуд IPO босгож олсон мөнгөний дийлэнх нь энд байршдаг байх боломжийг бүрдүүлж өгнө.

Монголын хөрөнгийн зах зээл жинхэнэ утгаараа хөгжөөд 20 жил болчихлоо гэж төсөөлье л дөө. Таны санаанд чухам ямар төрх бууж байна?

Монголын гайхам амжилттыг бэхжүүлэн түшиж буй хөрөнгийн бирж санаанд минь хамгийн түрүүнд бууж байна. Байгалийн баялгаа зөв зохистой ашигладаг, зөв дэд бүтцийг бүтээж чадсан мөн ашигт малтмал нь дэлхийн зах зээлд маш хүчтэй өрсөлдөхүйц байр суурьтай болчихсон, ард түмэн нь чинээлэг амьдрах нөхцөл бүрдсэн, хөрөнгө оруулалтыг сороонз мэт татдаг Азийн ТОР 10 орны нэг болон гялалзаж яваа улсыг би харж байна.

Хүмүүс Бриксийн орнууд болон Индонез тэргүүтэй улсын хөгжлийг ярих дуртай байдаг. Тэгвэл дээрх орнууд Монголын амжилтын тухай ярьдаг болоосой гэж хүсэж байна. Тэр үед бидний түншлэлийн харилцаа ард нь явж байгаасай. ■

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ



УУЛ УУРХАЙН САЛБАРТ ШИНЭ ЭРИН ҮЕ ЭХЭЛЛЭЭ

Б.БАЯРТОГТОХ

Дэлхийн гурав дахь том зэсийн уурхай болох Оюутолгойн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах Баяжуулах үйлдвэр шинэ оны өмнөхөн ашиглалтад оров. Улаанбаатар хотоос 600 гаруй км-ийн зайд эл баярт үйл явдал тохиож, үйлдвэрийн нээлтийг хэвлэл мэдээллийн 50 гаруй сэтгүүлч сурвалжилсан билээ.

Дэлхийн гурав дахь том зэсийн уурхай болох Оюутолгойн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах Баяжуулах үйлдвэр шинэ оны өмнөхөн ашиглалтад оров. Улаанбаатар хотоос 600 гаруй км-ийн зайд эл баярт үйл явдал тохиож, үйлдвэрийн нээлтийг хэвлэл мэдээллийн 50 гаруй сэтгүүлч сурвалжилсан билээ. Баяжуулах үйлдвэрийн нээлтийн арга хэмжээнд Уул уурхайн сайд Д.Ганхуяг тэргүүлсэн УИХ, Засгийн газрын төлөөлөл болон “Оюутолгой” компанийнхан нийлсэн нүсэр баг Өмнөговь аймгийн Ханбогд сумын Оюутолгойн онгоцны буудалд газардсан юм. Мөн орон нутгийнхан нээлтэд уригдсан байв. Баяжуулах үйлдвэрийн нээлт шинэ жилтэй зэрэгцэж тааарсан нь түүхэн үйл явдлын хүчийг сулруулах шиг болсон. Магадгүй, баярын сүрэнд дарагдсан байх.

Зэс, алт, мөнгө, молибден агуулсан Оюутолгой ордын Баяжуулах үйлдвэр нь хоногт 96 мянган тонн, жилдээ 35 сая тонн баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай. Үйлдвэрлэлийн хүчин чадлаараа Монгол Улсын хамгийн том бүтээн байгуулалт төдийгүй өндөр технологи бүхий аж үйлдвэрийн цогцолбор юм. Сонирхуулахад Баяжуулах үйлдвэрийн хүдэр хадгалах байгууламж Монгол Улсын хамгийн том спортын цогцолбор /нисэхийн замд байрлах /-оос ч том. Үндсэн бутлуурын туузан дамжуулага нийслэлийн Энхтайваны гүүрээс даруй долоо дахин урт. Улаанбаатар хотод



Нарны гүүрийг гурван жилийг хугацаанд барьсан бол Оюутолгойн бүтээн байгуулалтын их ажлыг хоёр жил хагасын хугацаанд нугалжээ. Баяжуулах үйлдвэрийг бүтээн байгуулахад 100 ширхэг Эрх чөлөөний хөшөө, гурван ширхэг Эйфелын цамхагтай тэнцэх хэмжээний төмөр карказ ашигласан тухай Оюутолгойнхон сонирхуулж байлаа.

“ОюутолгойнБаяжуулахүйлдвэрийн нээлтэд үйлдвэрээ төлөөлж оролцож байгаадаа баяртай байна. Эрдэнэт үйлдвэр 35 жилийн түүхтэй. Тэгвэл манай үйлдвэрийн “дүү” гэж хэлэх шинэ үйлдвэр дэлхийн хэмжээний техник технологийг нэвтрүүлж байгаад олзуурхаж байна” хэмээн Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн баяжуулах цехийн дарга Ш.Баатархүү нээлтийн үеэр сэтгэгдлээ хуваалцсан юм. “Баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтад дэлхийн 44 орны 15 мянган ажилтан гар бие оролцсон” гэж Оюутолгой компанийн ерөнхийлөгч бөгөөд гүйцэтгэх ерөнхий захирал Камерон МакРей ёслолын үеэр онцлон тэмдэглэсэн. Баяжуулах үйлдвэр энэ сарын сүүлчээр зэсийн баяжмалаа гаргана. Ирэх зургадугаар сараас бүтээгдэхүүнээ БНХАУ-д экспортолж эхэлнэ. 2016 он гэхэд гүний уурхайг ашиглалтад оруулж, 2019 оноос уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллах юм. Учир нь нийт баялгийн 80 гаруй хувийг далд уурхайгаас олборлоно. Тиймээс ирэх долоон жилийн хугацаанд төслийн барилга, бүтээн байгуулалтын ажил үргэлжилнэ гэсэн үг. Оюутолгойн ордын нийт геологийн нөөцийг 45 сая тонн зэс, 1.8 мянган тонн алт, 6.4 тэрбум тонн хүдэртэй хэмээн бүртгэжээ. Эдийн засгийн үр ашигтай нөөц нь 25 сая тонн зэс, нэг мянган тонн алт, 2.6 тэрбум тонн хүдэр.

Баяжуулах үйлдвэрийг асаах товчлуурыг дарсан Уул уурхайн сайд Д.Ганхуяг “Баяжуулах үйлдвэр ашиглалтад орсноор Монгол Улсад үйлдвэрлэж байгаа зэсийн баяжмал 80, нийт экспортын өсөлт 30-40, ДНБ-д эзлэх уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээ 20 хувиар тус тус нэмэгдэх төлөв бий. Түүнчлэн манай улс зэс олборлогч 50 гаруй орноос 15 дугаар байрт жагсах боломж бүрдэж байна” хэмээн нээлтийн үеэр онцлов. Баяжуулах үйлдвэр нунтаглан хөвүүлэх баяжуулах технологийг ашиглана хэмээн Оюутолгой компанийн баяжуулах үйлдвэрийн мэргэжилтэн М.Ганболд тайлбарласан юм. Баяжуулах үйлдвэр нь багахан хэмжээний зэс агуулсан хүдрийг 30 орчим хувийн зэс агуулсан баяжмал буюу Оюутолгойн эцсийн бүтээгдэхүүн болгон хувиргадаг байгууламж. Уг үйлдвэр нь хүдрийн агуулах, хайргын бутлуур, баяжуулах үйлдвэр, баяжмал хадгалах агуулах, хаягдал өтгөрүүлэгч зэргээс бүрддэг. Уул уурхайн сайдын хэлснээр “Шинэ зууны эхэн үед тохиож буй манай улсын хамгийн томд тооцогдох энэ бүтээн байгуулалт булган сүүлтэй байж, Монголын геологи, уул уурхайн салбарт шинэ эрин үеийг эхлүүлж, Монголын ард түмэн болон хөрөнгө оруулагч талуудад өгөөж арвинтай байх болтугай”.

Түүх давтагдаж байна

Баяжуулах үйлдвэрийн нээлтэд оролцсон төлөөлөгчдийн сэтгэгдлийг хүргэж байна

Д.Ганхуяг
/Уул уурхайн сайд/

-Монгол Улсад уул уурхайн салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойн босгон дээр, Монгол Улсын Засгийн газар болон “гуравдагч хөрш”-ийн хөрөнгө оруулагчдын хамтарсан Оюутолгой компани нь уг төслийн барилга, бүтээн байгуулалтын эхний шатны ажлыг амжилттай хийж гүйцэтгэлээ. Монгол Улсын эдийн засгийн бүтцийг сайжруулах, салбарын техник-технологийн болоод менежментийн түвшинг бүхэлд нь дээшлүүлэхээс гадна Монгол Улсын эдийн засгийг эрчимжүүлж хөгжлийн шинэ шатанд гаргаж, олон улсын тавцанд Монгол Улсын нэр хүндийг өсгөхөд чухал ач холбогдолтой үйл явдал болж байна. Оюутолгой үйлдвэрийг яаралтай улсын комисст хүлээлгэн өгөх хэрэгтэй.



Камерон МакРей /“Оюутолгой” компанийн ерөнхийлөгч бөгөөд гүйцэтгэх ерөнхий захирал/

-Төсөл хуваарийн дагуу урагшилж байна. Оюутолгойн баялгийн 80 хувийг далд уурхайгаас олборлоно. Тиймээс бидний аяллын зөвхөн 20 хувь өндөрлөж байна. Далд уурхайн бүтээн байгуулалттай зэрэгцэн эрчим хүчний шинэ эх үүсвэрээ барих ажилд анхаарч эхэлнэ. Бид Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс баяжуулах үйлдвэрийг нээх хүртэл ололт амжилтаар дүүрэн байлаа. “Оюу толгой” ХХК Монгол Улсын түүхэн дэх хамгийн том, хамгийн шилдэг технологитой уурхайг барьж байгуулахын зэрэгцээ нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж байна. Өнөөдөр бид Оюутолгойн ил уурхай, баяжуулах үйлдвэрийг богино хугацаанд бүтээн байгууллаа, ирээдүйд бүтээн байгуулалтын болон үйлдвэрлэлийн олон ололт амжилт биднийг хүлээж буй.

Н.Алгаа /Уул уурхайн үндэсний ассосиацын гүйцэтгэх захирал/

-Монголын уул уурхайн салбар дэлхийн түвшинд хүрч буйн илэрхийлэл нь Оюутолгойн баяжуулах үйлдвэр. Уг үйлдвэр ашиглалтад орсноор Монголын эдийн засаг 20 хүртэлх хувиар өснө. Түүнчлэн татварын орлого 20-70 хувиар урт хугацаанд тогтвортой өсөх боломж бүрдэж байна. Баяжуулах үйлдвэр зөвхөн уул уурхайн салбарт бус Монголын эдийн засагт гарч буй шинэ эргэлт. Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрээс хүчин чадал, хэмжээний хувьд дөрөв дахин том Баяжуулах үйлдвэр гэдэг нүсэр бүтээн байгуулалт юм.

Су.Батболд /УИХ-ын гишүүн/

-Оюутолгой төсөл Монголын нийгэм, эдийн засгийн амьдралд урьд өмнө байгаагүй боломж, чадлыг авчирна гэж найдаж байна. Уг төсөл Монголын анхны томоохон хэмжээний хөрөнгө оруулалтын төсөл. Гуравдагч орны томоохон хөрөнгө оруулалттай компани үндэсний хэмжээний төслийг амжилттай хэрэгжүүлж байгаад талархалтай хандах учиртай.

Пайпер Энн Уинд Кампбелл /АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд/

-Монголчууд урагшаа нэг чухал алхам хийснийг харахад гайхалтай.

Г.Батсүх /Оюутолгой төслийн ТУЗ-ийн дарга/

-Оюутолгой төслийн нэгдүгээр шатны үйл ажиллагаа өндөрлөж байна. Баяжуулах үйлдвэр уурхайн “цохилох зүрх” нь. Тиймээс “зүрх цохилж” байж бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Үйлдвэр богино хугацаанд ашиглалтад орж, бүтээгдэхүүнээ цаг алдахгүй боловсруулах нь эргээд нийгэм, эдийн засгийн амьдралд ашиг тусаа өгөх эерэг талтай. Монгол орныхоо хөрсөн дээр орчин цагийн үйлдвэрлэл, технологийн үнэт зүйлсийг ийнхүү нутагшуулан суурьшуулж байна. Түүнчлэн уул уурхайн салбарт дэлхийд өрсөлдөхүйц мэдлэг, ур чадвар, дадлага туршлагатай “хүний капитал”-ын цоо шинэ залуу үеийг төрүүлэн өсгөж байгаагаараа бид бахархаж байна. Монголын уул уурхайн салбарт нэн шинэ үеийн түүх эхэлж байна.

П.Цагаан /Оюутолгой төслийн ТУЗ-ийн гишүүн/

-Оюутолгой төслийг зөв голдирлоор нь явуулбал Монгол Улсын эдийн засагт асар их нөлөө үзүүлнэ. Өнгөрсөн 100 жилд Монголын ард түмэн тусгаар тогтнол, улс төрийн эрх чөлөөгөө олох гэсэн үе байлаа. Харин ирэх 100 жил эдийн засгийн хөгжлийн цэцэглэлтийн шинэ үе байна гэж найдаж байна.

М.Дамдинсүрэн /Монголын ашигт малтмалын баяжуулагчдын холбооны хүндэт ерөнхийлөгч/

-Дэлхийд тэргүүлэгч Оюутолгой төслийн Баяжуулах үйлдвэрийн нээлтэд оролцож байгаад туйлаас баяртай. Оюутолгой төсөл дэлхийн хэмжээнийх. Тиймээс талын монголчууд дэлхийн хэмжээнд хүрч сэтгэх цаг иржээ. Зэс, молибдений хамгийн том орд болох Эрдэнэтийн овооны баяжуулах үйлдвэрийг 1978 онд нээж байсан. Тухайн үед үйлдвэрийн анхны секц дөрвөн сая тонн хүдэр баяжуулах хүчин чадалтай ашиглалтад орж байлаа. Нээлтэд нь өнөөдрийнх шиг 1000 гаруй хүн оролцож байсан. Түүх давтагдаж байна. Монгол Улсын уул уурхайн салбар XX зуунд нэг том бүтээн байгуулалтыг хүлээж авч байсан нь уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр. Тэгвэл XXI зуунд монголчууд Оюутолгойг хүлээн авч байна. ■

ҮЗЭЛ БОДОЛ

Эрүүл мэндийн даатгал, ГЕРМАНЫ ТУРШЛАГА



Б.Лакшми /Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн гүйцэтгэх захирал/

Даатгалын оновчтой тогтолцоо нь эрүүл мэндийн салбарын хувьд ямар чухал байдгийг ХБНГУ-ын жишээгээр харуулах гэж оролдъё.

Иргэд нь эрүүл чийрэг байж гэмээнэ бүтээмж нь дээшилж урт насалдаг учраас улс бүр эрүүл мэндийн тогтолцоогоо аль болох оновчтой бүрдүүлэхийг боддог. Европын ихэнх орон энэ тал дээр дэлхийд дээгүүрт ордог бөгөөд ХБНГУ-ыг авч үзэхэд хүн бүрт тохирсон эрүүл мэндийн даатгалын тогтолцоо бий болгож чаджээ. Статистик үзүүлэлтээс харахад тус улсад эрэгтэйчүүдийн дундаж наслалт 80, эмэгтэйчүүдийнх 85 байх жишээтэй. Тэгвэл монгол хүн дунджаар хэд насалж байна вэ? Эрэгтэйчүүд нь 66 насалж байхад эмэгтэйчүүд нь дунджаар 71 насалдаг ажээ. Манай эрүүл мэндийн салбар олон жилийн турш нэлээд шүүмжлэлд өртөөд байгаа ч цогц шинэчлэл хийж чадаагүйн улмаас бодитой өөрчлөлтүүд гарсангүй.

Даатгалын оновчтой тогтолцоо нь эрүүл мэндийн салбарын хувьд ямар чухал байдгийг ХБНГУ-ын жишээгээр харуулах гэж оролдъё. Тус улсын эрүүл мэндийн салбарын гол оролцогч талууд бол даатгалын байгууллагууд (улсын болон хувийн), үйлчлүүлэгчид буюу даатгуулагчид, эмнэлэг болон эмч нар юм. Даатгалын байгууллагууд нь эмнэлгүүдтэй цахим хэлбэрээр холбогдсон байдаг. Даатгалд хамрагдсан хүнд түүний хувийн мэдээлэл бүхий цахим картыг даатгалын байгууллагаас нь олгодог. Эмчид үзүүлэх буюу эмнэлэгт хэвтэх тохиолдолд уг цахим картаа уншуулах бөгөөд түүний дараа эрүүл мэндийн байгууллагын ажилтан үзлэгийн хуудас хэвлэн өгч, үйлчлүүлэгчээр гарын үсэг зуруулдаг. Ингэснээр тэр хүн эмнэлгийн үйлчилгээ авсан нь үнэн бөгөөд даатгалын байгууллагаас төлбөрийг нь нэхэмжлэхийг зөвшөөрч буйгаа нотолно. Харин одоо оролцогч талуудын талаар дэлгэрэнгүй танилцуулъя.

1. Даатгалын байгууллага. Эрүүл мэндийн даатгалын байгууллагууд нь улсынх, хувийнх, мэргэжлийн холбоодынх зэрэг олон төрөл байна. Сар бүрийн шимтгэлийн хэмжээ, эрүүл мэндийн үйлчилгээ зэргээрээ даатгалын байгууллагууд ялгаатай байдаг ч даатгуулагчийн наснаас хамааралд өөр өөр хураамж авах ижил зарчим баримтална. Жишээ нь 20-30 насны хооронд сар болгон төлөх даатгалын хураамж бага байдаг бол 30, 40, 50 нас хүрэх бүрт энэ хэмжээ эрс нэмэгддэг. Хүн нас ахих тусам өвдөх магадлал өсдөг учраас ингэж буй хэрэг. Түүнчлэн нэг гэр бүлийн хүмүүс тусдаа хураамж төлөх шаардлагагүй, гэр бүлийн даатгалтай байх бөгөөд хүүхдүүд 20 нас буюу дээд сургууль төгсөх хүртлээ түүнд хамрагддаг.

Шимтгэлийн хэмжээ нь бага байдаг бөгөөд сар бүр ажил олгогч болон ажилтны цалингаас суутгаж авдаг учраас ихэнх хүн улсын даатгалд хамрагдсан байна. Тухайн хүний сарын орлогоос хамаарч хураамжийн хэмжээ өөр байх бөгөөд бага орлоготой хүмүүс арай бага шимтгэл төлдөг ч адилхан үйлчилгээ авах эрхтэй. Гэвч улсын даатгалд хамрагдсан хүмүүс эмнэлэгт үзүүлэхдээ дугаарлаж хүлээх шаардлага гардгийн гол шалтгаан нь эмч нарт очих үйлчилгээний хөлс нь арай бага байдагтай холбоотой байх. Харин хувийн даатгалд хамрагдсан хүмүүс улсын эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлөх шаардлагагүй (ажил олгогч нь ч мөн төлөхгүй) бөгөөд сар бүр харьцангуй өндөр хураамж өгдөг. Эмч болон эмнэлэг хувийн даатгалтай хүмүүсээс илүү өндөр төлбөр авдаг учраас түргэн шуурхай үйлчилгээ үзүүлдэг. Мэргэжлийн холбоодын даатгалд тодорхой мэргэжлээр ажиллаж буй хүмүүсийг даатгуулдаг бөгөөд ажил олгогч нь бас давхар хураамж өгөх үүрэгтэй. Зарим мэргэжил өвчлөлийн эрсдэл ихтэй байдаг болохоор уг даатгалд хамрагдаж илүү хураамж төлдөг бөгөөд илүү үйлчилгээ авах эрхтэй байдаг.

2. Үйлчлүүлэгч. Үйлчлүүлэгч нь хуулиар давхар үүрэг хүлээнэ. Тодруулбал, өвдөөгүй байсан ч урьдчилан сэргийлэх үзлэгт заавал хамрагдаж байх ёстойг бүр хуульчлаад өгчихсөн. Ингэж байж л өвдсөн тохиолдолд эмчилгээний зардлаа даатгалын байгууллагаар гаргуулах эрхтэй болно гэсэн үг. Урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамрагдахдаа эмнэлэг болон

эмчээ өөрөө сонгож, цаг авч үзүүлнэ. Үүнд дараах үзлэгүүд хамрагддаг:

Шүд эмчлэх зардал их байдаг болохоор бас тусдаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагддаг. Хүүхдийг хоёр наснаас нь авахуулаад жилд хоёр удаа шүдний эмчид үзүүлэх ёстой. Ингэж байнга урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсанаар жишээ нь 40 насандаа хиймэл шүд хийлгэх шаардлага гарвал даатгалын байгууллагаас төлбөрийнхөө 80 хувийг авна.

3. Эмнэлэг болон эмч нар. Эмнэлэг болон эмч нар нь үзүүлсэн үйлчилгээнийхээ төлбөрийг даатгалын байгууллагаас авдаг. Эмнэлэг бүр орлого ихтэй байхын тулд чанартай эмчилгээ, найрсаг үйлчилгээ, эсвэл ямар нэг өвчнийг анагаах тал дээр илүү мэргэшсэн байдал зэргээр олон үйлчлүүлэгч татахыг эрмэлзэнэ. Харин эмч нарын хувьд мөн олон үйлчлүүлэгчтэй байхын хэрээр өндөр цалин авдаг ч алдаа гаргасан тохиолдолд хариуцлага тооцох байдал нь хатуу бөгөөд хяналттай байдаг.

ХБНГУ-ын иргэд доорх байдлаар урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагддаг

Эрэгтэй хүмүүс	20 наснаас жил бүр нэг удаа умайн хүзүүний болон умайн хавдраас урьдчилан сэргийлэх эмэгтэйчүүдийн үзлэгт хамрагдаж байх.
	Шээсний шинжилгээ өгч хламид бактери бий, эсэхийг шалгуулах. Энэ нь зарим тохиолдолд үргүйдэлд хүргэдэг учраас эрт оношловол эмчлэх боломжтой.
	30 наснаас эхлээд жилд нэг удаа хөхний хавдраас урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах.
	35 наснаас хоёр жилд нэг удаа арьсны хавдраас урьдчилан сэргийлэх бүтэн биеийн арьс, салст болон хуйхны үзлэг хийлгэх.
	35 наснаас хоёр жилд нэг удаа урьдчилан сэргийлэх ерөнхий үзлэгт хамрагдаж чихрийн шижин, зүрхний болон бөөрний үйл ажиллагаагаа шалгуулдаг. Үүнд цус, шээс болон бусад шаардлагатай шинжилгээ багтана.
	50 наснаас ходоодны гарах хэсэг, 12 хуруу гэдэс дурандуулах шинжилгээ өгнө.
	55 насандаа ходоодоо дурандуулах ёстой. Тэгээд 10 жилийн дараа дахин дурандуулна.
	50 наснаас эхлээд хоёр жилд нэг удаа хөхний хавдраас урьдчилан сэргийлэх мамографийн шинжилгээ хийлгэх.
Эмэгтэй хүмүүс	35 наснаас хоёр жил тутамд арьсны хавдраас урьдчилан сэргийлэх бүтэн биеийн арьс, салст болон хуйхны үзлэг хийлгэх шаардлагатай.
	35 наснаас хоёр жил тутамд урьдчилан сэргийлэх ерөнхий үзлэгт хамрагдаж чихрийн шижин, зүрхний болон бөөрний үйл ажиллагаагаа шалгуулдаг. Үүнд цус, шээс болон бусад шаардлагатай шинжилгээ багтана.
	Түрүү булчирхайн томролыг эрт оношлох зорилгоор 45 наснаас жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах.
	45 наснаас ходоодны гарах хэсэг, 12 хуруу гэдсийг дурандах шинжилгээ хийлгэх.
	55 насандаа ходоодоо дурандуулах ёстой. Тэгээд 10 жилийн дараа дахин дурандуулах нь зүйтэй.

Энэ бүхнээс үзэхэд ХБНГУ-ын эрүүл мэндийн салбарын оролцогч талуудын хоорондын уялдаа холбоо маш тодорхой, цэгцтэй байгаа юм. Иргэдээ эрүүл чийрэг байлгахын тулд байнга эмнэлэгт үзүүлж, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах нөхцөлийг ийнхүү даатгалын тогтолцоог ашиглан бүрдүүлж чаджээ.

Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх нь төр засгийн зайлшгүй үүрэг. Гэтэл Монгол Улсад эмнэлгийн үйлчилгээ хүрэлцээгүй болоод чанаргүй хэвээр байна. Ялангуяа хөдөө орон нутагт энэ байдал маш хэцүү байгаа билээ. Эрүүл мэндийн даатгалын салбар болоод томоохон эмнэлгүүдийг төр атгадаг бөгөөд шинэчлэл хийж чадахгүй байна. Хэчнээн төрийн өмчит байлаа ч хувийн байгууллага шиг удирдаж байж л амжилтад хүрнэ. Үүний зэрэгцээ иргэд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж сураагүй учраас өвчилж, өвчин нь хүндэрч, ужгирч, улмаар эмнэлгүүдийн ачааллыг нэмэгдүүлж байна. Тиймээс Монголын бодлого боловсруулагчид шинэчлэл хийж, эрүүл мэндийн тогтолцоогоо оновчтой бүрдүүлэхийн тулд ХБНГУ мэтийн бусад орны туршлагаас судлах хэрэгтэй. ■

ЭЛЧИН САЙД



Фотог Э. Зоригт

Х.ХУЛАН

Мөн хамгийн чухал зүйл бол Монгол Улс нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх сонирхолтой байгаа явдал юм.

ТҮҮХИЙ ЭДЭЭ ХӨГЖЛИЙН **ТУЛГУУР БОЛГОХ НЬ ЧУХАЛ**

ХБНГУ-ын Элчин сайд Петер Шаллер хуучнаар Зүүн Германд төрсөн. Таван настайд нь түүний ээж тухайн үед Баруун Германд амьдарч байсан өвөө, эмээ рүү нь шилжин суурьшжээ. Дунд сургуулиа төгсөөд Германы зэвсэгт хүчинд элсэж, гурван жил цэргийн алба хаасан аж. Үүний дараа нь тэрбээр Нордрайн-Вэстфален мужийн Бохум, Мюнстер хотуудад нийгмийн шинжлэх ухааны чиглэлээр (сэтгэл судлал, нийгэм судлал, сурган хүмүүжүүлэх ухаан) суралцсан байна. Их сургуулиа дүүргэсний дараа оюутнуудад карьерын талаар зөвлөгөө өгөх ажил хийж байгаад улмаар дипломат албанд оржээ.

Эдүгээ Шаллер Зүүн Хойд болон Төв Азид 30-аад жил дипломатчаар ажиллаж байна. Тэрбээр Хятад, Туркменистан, Хойд Солонгос, Кабо Вердед ажиллаж байв. Түүнчлэн ОХУ-ын Санкт-Петербург хотод Ерөнхий консулын алба хашиж байснаас гадна Афганистан, Куба, Того, Брюссель, Будапештэд богино хугацаагаар ажиллаж байсан туршлагатай нэгэн. ▸▸

-Таны хувьд дипломатчийн ажлын юунд нь хамгийн ихээр татагддаг вэ?

-Дипломатчийн мэргэжлийг сонгох болсон шалтгаан гэвэл дэлхийн улс орнуудыг ихэд сонирхдогтой минь холбоотой. Янз бүрийн соёл, зан заншил, нийгэмтэй танилцах дуртай. Нийгмийн шинжлэх ухаан судалсаны хувьд эдгээрийг мэргэжлийн хүний нүдээр хардаг. Мэдээж хэрэг би аялах дуртай. Дипломатчийн ажил мэргэжил хүмүүстэй маш өргөн харилцаанд орж, хамтран ажиллах боломж олгодог нь надад маш их таалагддаг даа.

-Янз бүрийн соёл, зан заншлыг сонирхох болсон шалтгаан?

-Аялал бол дипломатч хүний амьдралын нэгээхэн хэсэг байдаг. Миний амьдралд аялал маш чухал байр суурь эзэлдэг. Би оюутан ахуй цагаасаа л эхэлж аялсан, ихэнхдээ Ойрхи Дорнод, Зүүн Өмнөд Ази, бас мэдээж хэрэг Европоор. Дипломатчаар ажиллах нь дэлхий ертөнцтэй гүн гүнзгий танилцах завшаан олгодог.

-Та анх Монгол Улстай яаж холбогдсон бэ?

-Анх 1984 онд Бээжингээс Москва руу төмөр замаар аялах замдаа Улаанбаатараар дайран өнгөрч байсан. Дараа нь 1993 онд Пхеньянд ажиллаж байх үедээ Улаанбаатар дахь Германы Элчин сайдын яаманд ажилладаг мэргэжил нэгт нөхөр маань эхнэр бид хоёрыг урьж, Монголд хоёр дахиа ирсэн. Бид хоёр Хархорин руу, мөн нийслэл хотын ойролцоо газруудаар аялан хоёр долоо хоногийг өнгөрүүлсэн. Энэ нь танай улсыг би гучаад жилийн өмнөөс сонирхох болсныг харуулж байгаа юм.

-Таныг Элчин сайдаар томилогдон ажилласнаас хойш Монголд ямар өөрчлөлт гарав?

-Намайг ирснээс хойш хоёр орны хооронд хоёр ч удаагийн дээд хэмжээний айлчлал зохион байгуулагдсан. Эхнийх нь ХБНГУ-ын канцлер Ангела Меркелийн Монголд хийсэн айлчлал. Энэ нь түүхэнд манай улсын Засгийн газрын тэргүүний Монголд хийсэн анхны айлчлал болсон. Үүнээс хойш зургаан сарын дараа Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Германд болон Европод төрийн айлчлал хийсэн

Би Ерөнхийлөгчийг айлчлалын үеэр дагаж явсан. Энэ хоёр айлчлал нь манай хоёр орны хамтын ажиллагаанд ихээхэн түлхэц өгсөн гэж хэлж болно. Энэ нь бидний ажилд илт мэдрэгдэж байна. Айлчлалын дараа бид хийх ажил ихтэй болсон. Ялангуяа эдийн засгийн солилцоогоо нэмэгдүүлэх тал дээр илүү анхаарах шаардлагатай байгаа. Бүх төрлийн хамтын ажиллагаа дээрх дээд хэмжээний айлчлалын үр дүнд улам өргөжиж байна.

-Герман-Монголын эдийн засгийн хамтын ажиллагаа өнөөдөр ямар түвшинд байна вэ?

Хоёр орны хамтын ажиллагаа маш сайн байгаа гэж би түрүүн хэлсэн. Улс төр, соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагааны хувьд гомдоллох зүйл үнэхээр алга. Харин эдийн засгийн хамтын ажиллагааны хувьд бид боломжоо бүрэн гүйцэд ашиглаж чадахгүй байна гэж талууд аль аль нь үзэж байна. Эдийн засгийн харилцаа тодорхой түвшинд хөгжиж байгаа, бидэнд байгаа потенциалаа ашиглаж чадвал илүү өндөр түвшинд гаргах бүрэн боломжтой юм.

Бид энэ чиглэлд эдийн засгийн харилцаагаа илүү өндөр түвшинд гаргахын төлөө ажиллаж байна. Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр санамж бичгүүдэд гарын үсэг зурсан. Яг одоо нүүрс шингэрүүлэх үйлдвэр байгуулах тухай яригдаж байгаа. Коксжуулсан нүүрсний





үйлдвэр барих тухай санамж бичигт гарын үсэг зурсан. Түүнчлэн газрын ховор элемент олборлолтын тухай хэлэлцэж буй. Мөн Германы талаас “Ферростал” гэхчлэн тодорхой төслүүд дээр хамтрах хүсэлтэй компанийн төлөөллүүд байна.

Энэ чиглэлийн хамтын ажиллагаанаас гадна Монголын дэд бүтцийг шинэчлэх талаар мөн ярилцаж байгаа. Саяхан Бавари мужийн Эдийн засгийн төрийн нарийн бичгийн дарга айлчилсан. Бид энэ мэтчилэн олон салбарт хамтын ажиллагаагаа бэхжүүлэхээр ажиллаж байна.

-ГОУХАН-ийн “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга” хөтөлбөрөөс зарласан “Компанийн нийгмийн хариуцлагын форум”-ын үеэр нийгмийн хариуцлагыг зөвхөн компаниар хязгаарлахгүй, мөн хувь хүн нэг бүрээс эхлүүлэх шаардлагатай гэж хэлсэн. Энэ уриаг амьдрал дээр хэрэгжүүлэхийн тулд “дэлхийн иргэн” юунд хамгийн гол анхаарлаа хандуулвал зохих вэ?

-Компанийн нийгмийн хариуцлага гэдэг ойлголт өнөөдрийн уриа болсон. Гэхдээ эдгээр хууль, дүрмийн хэрэгжилт хувь хүнээс эхэлдэг гэдгийг бид ойлгох ёстой. Компанийн нийгмийн хариуцлага нь компанид бус, харин компанийн нэрийн өмнөөс ажиллаж буй хувь хүмүүст хамаатай ойлголт.

> Монгол Улс түүхий эдэд суурилсан аж үйлдвэржсэн орон болоход бид үнэтэй хувь нэмэр оруулж чадна. Канцлер Меркелийн айлчлалын үеэр эрдэс түүхий эд, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан.

Энэ нь нийгмийн бүхий л дүрэм журам, хууль тогтоомжид хамаатай. Хүмүүс өөрсдийнх нь болоод нийгмийн, цаашилбал компанийх нь ашиг сонирхол, тусын тулд эдгээр хууль, дүрмийг мөрдөх шаардлагатай гэдгийг сайтар ухамсарлах ёстой. Жишээлбэл, бизнесийн үй ажиллагаа эрхлэх, эсвэл төсөл хэрэгжүүлэх явцдаа хээл хахуулийн асуудалд ямар нэг байдлаар холбогдвол тухайн хүн хараат бус байдлаа алдана. Өөрөөр хэлбэл, үйлдлийн эрх чөлөөгүй болно. Хувь хүн тэдгээр хууль дүрмийг дагаж мөрдсөнөөр эрх чөлөөт бие хүн хэвээр байж, хараат бус байдлыг хязгаарладаг тогтолцооны хэсэг болохгүй байх нөхцөл бүрдэх юм.

-Таны ярьсан дипломат айлчлалуудаас хойш уул уурхайн салбарт ямар өөрчлөлт гарсан бэ?

-Германд ч, Монголд ч хоёр орны эдийн засаг өөр хоорондоо маш сайн уялдан хөгжих боломжтой талаарх мэдээлэл нэлээд сайн түгсэн гэж бодож байна. Тухайлбал, танайд түүхий эд баялаг байна. Германд түүхий эд хэрэгцээтэй. Гэхдээ хамгийн чухал зүйл бол Монгол Улс нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх сонирхолтой байгаа явдал. Монголчууд түүхий эд экспортлоод зогсохгүй, эх орондоо боловсруулах үйлдвэр байгуулж, нэмүү өртөг бүтээхийг зорьж байна. Энэ нь жишээлбэл, нүүрсийг түүхийгээр нь биш, коксжуулж, илүү үнэ хүргэхийг хэлж буй хэрэг.

Герман улс тэргүүлэх аж үйлдвэржсэн орнуудын нэг бөгөөд манайд аж үйлдвэрийн хүчин асар өндөр хөгжсөн. Тус тусын салбарт дэлхийд тэргүүлсэн компани манайд олон бий. Монгол Улс түүхий эдэд суурилсан аж үйлдвэржсэн орон болоход бид үнэтэй хувь нэмэр оруулж чадна. Канцлер Меркелийн айлчлалын үеэр эрдэс түүхий эд, аж үйлдвэр, технологийн салбарт хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан. Одоо хоёр орны Засгийн газар, компаниуд Монгол Улсыг хөгжүүлэхийн тулд хамтын хүчин чармайлт гаргах хэрэгтэй байна.

-Таны бодлоор Монгол Улсад боловсруулах аж үйлдвэрийг хэрхэн тогтвортой хөгжүүлэх вэ?

-Шинэ Засгийн газар бүрэлдэн тогтсоны дараа бид тодорхой төслүүдийн тухай ярих боломжтой болно байх гэж найдаж байна. Бидэнд хамтарч ажиллах олон боломж байгаа ч одоо бол байгаа санаануудаа бодит амьдрал дээр хэрэгжүүлэхийн төлөө хичээх цаг болжээ.

Германы бизнесийн тухайд гэвэл бид өндөр технологийн шийдэл санал болгож болно, гэхдээ бидэнд үүнээс ч илүү давуу тал байна. Эхний давуу тал гэвэл Германы бизнес эрхлэгчид урт хугацааны бизнес, хамтын ажиллагааг сонирхдог, өөрөөр хэлбэл богино хугацаанд түргэн ашиг олохыг бус, насан туршдаа хамтрах түнштэй болохыг чухалчилдаг явдал. Хоёр дахь давуу тал нь манай аж үйлдвэр байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулдаг. Түүнчлэн манайд эрчим хүчний хэмнэлттэй үйл ажиллагаа, технологи хөгжүүлдэг. Эрчим хүчээ хэмнэж, шаардлагатайгаас илүүг



зарцуулахгүй байх нь тогтвортой байдлын нэг хэсэг юм. Мөн манай компаниуд хамгийн сүүлийн үеийн стандарт ашигладаг. Дэлхийн аль ч өнцөгт орших Германы компанийн салбар өөрийн стандартаа л баримталдаг. Нийгмийн халамж, ажиллах хүчний асуудлыг ч Европын стандартын дагуу шийдвэрлэдэг. Өөр бас нэг давуу тал гэвэл манай компаниуд өөрийн ноу-хаугаа түншүүдтэйгээ хуваалцахад ямагт бэлэн байдаг. Энэ нь гадаадын ажиллагсдаа ажлын байран дээрх сургалтад хамруулах, эсвэл түнш байгууллагынхаа хүний нөөцийг чадавхижуулах, тэдний мэргэжлийн түвшинг дээшлүүлэх зорилгоор Герман руу илгээх асуудалд ч мөн хамаатай.

-Герман улс сэргээгдэх эрчим хүчээрээ дэлхийд тэргүүлдэг. Таны хувьд Монголын эрчим хүчний салбарыг хөгжүүлэх ямар боломж харагдаж байна?

-Танай улсын үндэсний хөгжлийн төлөвлөгөөнд ирээдүйд нийт эрчим хүчний эрэлтийн 15 орчим хувийг сэргээгдэх эрчим хүчээр хангана гэж заасан байгаа. Танай оронд нар ч байна, салхи ч байна. Монгол бол дэлхийн хамгийн нарлаг орны нэг. Ялангуяа говьд салхи маш ихтэй. Иймд танайх сэргээгдэх эрчим хүчний найдвартай хангамжтай болох бүрэн боломжтой гэж үзэж байна. Германы компаниуд энэ чиглэлээр дэлхийд манлайлдаг, иймээс би ч мөн энэ салбарт хамтран ажиллах сайхан боломжийг харж байна.

Мөн биомассын потенциал ч танайд байна. Энэ тал дээр Герман ихээхэн туршлагатай. Гэхдээ Монгол Улс эрчим хүч хэмнэх тал дээр томоохон боломжтой гэдгээ мартаж болохгүй. Жишээлбэл, бид байшин барилгын дулаалга хийх арвин туршлагатай. Улаанбаатар хот дахь социализмын үед баригдсан олон орон сууц эрчим хүчний үр өгөөжийн хувьд дутагдалтай байдаг. Тэдгээр барилгын дулааны хэмийг тохируулж болдоггүйгээс гадна дулаалга нь ч нэг их сайн биш. Яг энэ тал дээр бидэнд хамтран ажиллах томоохон боломж байгаа ба үүнийг дутуу үнэлж болохгүй. Улаанбаатар хотын захиргаатай хамтарсан “Экосити” хөтөлбөрийг бид хэрэгжүүлээд энэ жил дуусч байна. Эдгээр орон сууц эрчим хүчний хэмнэлтийн маш өндөр үзүүлэлттэй. Орон нутгийн засаг захиргаа ирээдүйд байшин барилгаа энэ стандартаар барих тохиолдолд их хэмжээний эрчим хүч хэмнэх болно.

-Уул уурхайн салбар Монгол Улсын орлогын дийлэнхийг бүрдүүлдэг. Гэвч улс орны хөгжил дан ганц салбарт тулгуурлах нь тэнцвэргүй хөгжил буюу Голланд өвчинд нэрвэгдэхэд хүргэнэ гэх мэт шүүмжлэл их бий. Таны хувьд уул уурхайд түшиглэх тал дээр ямар бодолтой байна?

-Мэдээж хэрэг Монгол байгалийн баялагтаа түшиглэнэ. Гэхдээ та бүхэн эдийн засгаа баялагтаа тулгуурлан, төрөлжүүлэн хөгжүүлэх хэрэгтэй. Монголд хөгжлийн түвшинг нь ахиулах шаарлагатай эдийн засгийн салбар олон байна. Жишээ нь, хөдөө аж ахуйд гэхэд л мал аж ахуй, газар тариаланд шинэ арга барил, технологи нэвтрүүлэх гэх мэт хөгжлийн орон зай хангалттай бий. Мөн монгол малын мах дэлхийд хамгийн чанартайд ордог гэж би хувьдаа боддог. Энэ нь жинхэнэ биологийн гаралтай мах. Монгол малын махыг Европ руу экспортолж, органик мах гэж борлуулах боломжтой. Аялал жуулчлалын салбарт ч сайжруулах зүйл маш их байна. Би олон улс орноор аялсны хувьд Монголын аялал жуулчлалын компаниуд Европын туршлага, ноу-хаугаас суралцах хэрэгтэй гэж зөвлөмөөр байна. Хотын шинэ захирагч замын хөдөлгөөний ачааллыг шийдвэрлэхэд чиглэсэн олон арга хэмжээ танилцуулсан. Гэвч хотын үйлчилгээний салбарыг бүхэлд нь сайжруулах шаардлагатай. Ерөнхийд нь тодорхойлвол, Монгол Улсад хэрэгцээтэй хамгийн гол зүйл бол ноу-хау. Хөгжингүй орнуудаас гадна бусад гадаад орны туршлагаас маш их суралцах хэрэгтэй. Гэхдээ гаднын туршлагыг шууд хуулбарлах бус, өөрийн орны нөхцөлд тохируулан нэвтрүүлвэл зохино. Мөн тээврийн салбарыг бүхэлд нь орчин үеийн шаардлагад нийцүүлэн сайжруулах нь цаашдын хөгжилд зайлшгүй чухал. Товчхондоо, танайх бүх талыг хамарсан хандлагыг баримтлах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, түүхий эдээ аль болох олон салбарыг хөгжүүлэх суурь болгон ашиглах ёстой. ■



Фотог Зохиогч


СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ

ГОЛ ДҮР

Э. ЗОРИГТ

Монголын уудам говь нутаг Сахарын цөлийн дараа орох хэмжээний нар, салхины нөөцтэй. АНУ-ын Үндэсний сэргээгдэх эрчим хүчний лабораторийн тооцоогоор Монголын нар, салхинаас нийт 2.6 сая мВт эрчим хүч үйлдвэрлэх боломжтой аж.

Эрчим хүч, эдийн засгийн өсөлт, улс орны хөгжил гээд бүх л зүйлийг байгальд ээлтэй болгохыг дэлхий нийт эрмэлзэж байна. Эл эрмэлзлэлээ “Ногоон хөгжил” гэж товчхон нэрлэдэг. Уг хөгжлийн гол агуулга нь өдөр ирэх бүр өсөн нэмэгдэж буй дэлхийн хүн амын хэрэгцээг яаж илүү эрүүл, байгальд ээлтэй технологит тулгуурлан бүтээх вэ гэдэгт оршиж байна. Өнөөдөр дэлхий дээр байгаа эрчим хүчний уламжлалт болон бусад хэрэглээг хангах нөөц 10 тэрбум хүнийг арай ядан тэжээнэ гэх судалгаа бий. Тэгвэл 2050 он гэхэд дэлхийн хүн ам дээрх тооноос давах таамаг бий. Тэр үед хүмүүс яах вэ. Хариултын нэг нь сэргээгдэх эрчим хүч тэргүүтэй байгальд ээлтэй шавхагдашгүй нөөцийг ашиглах юм. 2008 оноос хойш дэлхийн улс орнууд цэвэр эрчим хүчийг түлхүү ашиглах болж, нийт эрчим хүчний 20 орчим хувийг сэргээгдэх эрчим хүчнээс гаргаж авсан байна. Энэ тоо жил ирэх тусам өссөөр байгаа юм. Тухайлбал, Олон улсын сэргээгдэх эрчим хүчний агентлагаас гаргасан тооцоогоор 2050 он гэхэд дэлхийн нийт эрчим хүчний 50 орчим хувийг сэргээгдэх эрчим хүчнээс гаргаж авна гэжээ. Японы Фүкүшимагийн ослын дараахан ХБНГУ цөмийн эрчим хүчнээс татгалзаж, япончууд ч байгальд ээлтэй эх үүсвэрээр эрчим хүчний хэрэглээгээ хангах том зорилго дэвшүүллээ. Энэ мэт ногоон гэх тодотголтой хөгжлийн шинэ тайзан дээр Монгол Улсад гол дүрд тоглох боломж бий. Учир нь талын Монгол орон сэргээгдэх эрчим хүчний шавхагдашгүй арвин нөөцтэй.



...Яндаж болдоггүй далай шиг яасан баян нутаг вэ

Эрт дээр үеэсээ л монголчууд ийнхүү дуулж ирсэн. Үнэхээр Монгол дэлхийд гайхуулах олон баялагтай. Тухайлбал, дэлхий нийт Монголыг Чингис гэх нэрээр таньдаг байсан бол өдгөө нүүрсээр нь илүү мэддэг болсон. Манай улсын нүүрсний геологийн таамаг нөөц 163,2 тэрбум тонн, цаашдаа өсөх магадлалтай гэж тогтоосон байдаг. Энэ нь дэлхийн нүүрсээр баян орны эхний аравт багтах үзүүлэлт юм. Тиймдээ ч Монгол орны хувьд нүүрс нь эрчим хүчний үндсэн эх үүсвэр төдийгүй манай улсын эдийн засгийн хөгжлийг тодорхойлогч үнэт баялаг. Гэхдээ нүүрс түлж эрчим хүч гаргаж авдаг үе бага багаар "баяртай" болж байгаа энэ үед хар алт тушаал буурч харин сэргээгдэх эрчим хүчний шавхагдашгүй нөөц цол ахиж байна. Учир нь манай орны урд хэсгээр нарны болоод салхины нөөц асар их. Тодруулбал, Монголд нартай өдөр жилийн 280-аас дээш хоног байдаг бол 3.5 м/с-ээс их салхи жилийн 300 гаруй өдөр байдаг гэсэн судалгаа бий. Дэлгэрэнгүйг графикаас харна уу.

Шавхагдашгүй нөөцийг шалгарсан аргаар

Аливаа салбарыг хөгжүүлэхийн тулд гаднын хөрөнгө оруулалтыг татах нь эдийн засгийн шалгарсан арга гэдгийг эдийн засагч Д.Жаргалсайхан хэлсэн. Сэргээгдэх эрчим хүчний томоохон эх үүсвэр барихын тулд хөрөнгө, мөнгө ихээхэн шаардлагатай. Тиймээс тус салбарт гаднын хөрөнгө оруулалтыг татах нь зайлшгүй юм. Хэдийгээр зах зээл өөрөө зохицуулалт хийх боловч тус салбарт хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх нь төрийн үүрэг. ЭБЭХЯ-ны сайд асан Д.Зоригт "2007 онд батлагдсан Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль тус салбарт шинэчлэл авчирсан гэж хэлж болно. Хууль батлагдсанаар "Ньюком" компанийн 50мВт-ын салхин станцын ажил эхэлж. Монгол Улс 2020 он гэхэд эрчим хүчний нийт хэрэглээний 20 хувийг сэргээгдэх эрчим хүчээр хангана гэсэн том зорилгыг өмнөө тавьсан. Түүнчлэн "100 000 нарны гэрэл төсөл" амжилттай хэрэгжлээ. Дэлхийн хаана ч манай улс шиг өрхийн хэмжээнд сэргээгдэх эрчим хүчийг ийм өргөн хүрээнд ашигладаггүй. Энэ утгаараа манай малчид ногоон хөгжилд нэг том үлгэр дуурайлал болж буй хэрэг" гэсэн юм. Хууль батлагдсанаар тус салбарын хөгжлийн хаалгыг нээсэн гэж хэлж болох. Дэлгэрэнгүйг графикаас харна уу.

Хэдий тийм ч тус хуульд засч залруулах зүйл байгааг салбарынхан хэлж байсан. Хамгийн түрүүнд хөрөнгө оруулагчдын эрсдэлийг бууруулах, итгэл найдварыг дээшлүүлэхийн тулд хэд хэдэн өөрчлөлт хийх шаардлагатай аж. Үүнд:

-СЭХ-ний төслүүд хэрэгжих хугацаа харьцангуй урт, бараа материал,тоног төхөөрөмжийн үнэ, хэрэглээний үнэ хурдан өөрчлөгдөж байгаатай холбогдуулж үнэ тарифыг өөрчлөх боломжтой уян хатан болгох.

-СЭХ-ний эх үүсвэрээс эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний дагуу төлбөрийн механизмыг боловсронгуй болгох

-Сэргээгдэх эрчим хүчийг ашиглан дулаан үйлдвэрлэл нийлүүлэх үнэ тарифыг батлах

-Сэргээгдэх эрчим хүчнээс гаргаж авсан цахилгааны үнийг зах зээлийн горимд шилжүүлэх зэрэг асуудлыг яаралтай шийдэх хэрэгтэй аж.

Монголын эдийн засагт хийгдэж буй хамгийн том уул уурхайн бус хөрөнгө оруулалт бол Салхитын салхин парк. Өдгөө уг ажил 80 хувийн гүйцэтгэлтэй байгаа талаар "Ньюком" группын захирал Б.Бямбасайхан хэлсэн. Мөн ЭХЯ-ны сайд М.Сономпил "Салхитын салхин парк бол эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татсан сайн жишээ юм. Мөн 2020 онд гэхэд манай улс нийт эрчим хүчний хэрэглээнийхээ 20 хувийг сэргээгдэх эрчим хүчнээс гаргах зорилтыг тууштай хэрэгжүүлэх эхлэл" хэмээн тус ажлыг онцолсон юм. Энэ бол ердөө эхлэл. Монгол Улс эрчим хүчний диваажин орон болох боломж бидний өмнө

нээлттэй. Гэхдээ юманд учир, суманд занги бий. Ганц талыг барьж туйлшралгүй бүх төрлийн эрчим хүчний эх үүсвэрийг өөр хооронд нь уялдуулж ашиглах ёстой талаар холбогдох албаныхан хэлж байсан.

Азийн супер сүлжээ

Европчууд Сахарын цөлийг ашиглаж, улс орноо байгальд ээлтэй эрчим хүчээр хангах бодлого явуулж байна. Алтан наран элчээ харамгүй хайрладаг эл газар эрдэмтдийн тооцоолсноор нарны эрчим хүчний нөөцийн гуравны нэгийг ашиглахад л Европ тивийг бүхэлд нь эрчим хүчээр хангах аж. Харин Монголын уудам говь нутаг Сахарын цөлийн дараа орох хэмжээний нар, салхины нөөцтэй. АНУ-ын Үндэсний сэргээгдэх эрчим хүчний лабораторийн тооцоогоор Монголын нар, салхинаас нийт 2,6 сая мВт эрчим хүч үйлдвэрлэх боломжтой аж. “Блүүмберг” агентлагийн мэдээлснээр энэ нь дэлхийн бүх атомын цахилгаан станцуудын гаргаж байгаа эрчим хүчнээс даруй долоо дахин их юм байна. Энэ их нөөц Ази тивийн сонирхлыг хэдийнэ татсан. Тэр нь “Азийн эрчмийн супер сүлжээ” гэх төсөл юм. Японы “Софт” банк, БНСУ-ын КЕПКО, Монголын “Ньюком” групп хамтарч уг төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байгаа. Гол зорилго нь Монголын сэргээгдэх эрчим хүчний нөөцийг судлах, эдийн засгийн эргэлтэд оруулж, Азийн зах зээл рүү экспортлох боломжийг хайхад чиглэсэн үйл ажиллагаа явуулах аж. “Уг аварга төслийг бодит ажил болгох нөөц, боломж нь Монголд байна. Боломжийг хөгжил болгон хувиргах ёстой” гэдгийг “Ньюком” компанийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан хэлсэн. Түүнчлэн “Говийн салхинаас жилдээ 682 тэрбум кВт.цаг цахилгаан үйлдвэрлэх нөөцтэй. Эхнээс нь

Монгол орны сэргээгдэх эрчим хүчний нөөц

Салхи	2.55 их наяд кВт цаг
Нар	4.8 их наяд кВт цаг
Нийт	үйлдвэрлэлийн хүчин чадал 2.6 сая мегаватт

Эх сурвалж: СЭХҮТ

Өмнөговь аймгийн Цогтцэций суманд 300 мВт-ын хүчин чадалтай нар, салхины хосолсон станц барих ТЭЗҮ-г энэ онд боловсруулахаар байгаа. Тиймээс энэ бол мөрөөдөл бус бодит ажил болно” гэв. Харин төрийн зүгээс уул уурхайн орд газруудыг цэвэр эрчим хүчний эх үүсвэрээр хангах, газрыг уул уурхайн хайгуул, олборлолтын лицензтэй давхардуулан олгохгүй байх зэрэг асуудлыг шийдвэрлэсэн эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай байгаа аж. Азид ийм сүлжээ байгуулагдсанаар хөгжлийн ирээдүйн гарц цэвэр эрчим хүч хэмээн тодорхойлсон дэлхийг хэрсэн асар том сүлжээ бий болох юм. ■

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН

2013 оны 3 дугаар сарын 4-5

Монгол улс, Улаанбаатар хот

facebook.com/huralday twitter.com/huralday youtube.com/huralday

УСНЫ МЕНЕЖМЕНТ

УСАН ЗЭРЭГЛЭЭТ ГОВЬ

Э. ЗОРИГТ

Говийн бүсэд жилд дунджаар 100 орчим мм тунадас унадаг. Монгол орны гадаргын усны ердөө 20 хүрэхгүй хувь нь ногддог.

. . . Говь гэмээнэ говь билээ
Гол мөрөн байхгүй билээ
Гол мөрнийг нь хуу сорсон


Голдирол сайрын орон билээ хэмээн Дорнын их яруу найрагч Б.Явуухулан шүлэглэсэн нь бий.

Монгол орны 70 орчим хувийг тал хээр болон дээрх шүлэг мэт говь хэмээх голдирол сайрын нутаг эзэлдэг. Байгалийн араншинг аргадаж амьдардаг малчид нь ч усны хомсдолоос болоод ганц гэрээр нүүдэллэж амьдарна. Говийн зэрэглээ, ус мэт мяралзаж цөөн хэдэн мал, ганц бор гэрээс өөр эд хөрөнгөгүй мэт говийн ганц гэр дөрвөн улирлын алинд ч ажин түжин, амар тайван.

Говь нутгийн хэвлийд шунал хөдөлгөм их баялаг бий. Тэр их баялгийн зарим хэсгийг олборлохоор тив алгасан ирсэн уурхайчид их бүтээн байгуулалтыг хэдийнэ эхлүүлсэн. Ганц гэрээр амьдардаг говийнхны ажин түжин амьдрал ч цагийн аясаар их бүтээн байгуулалтын нүргээнд нэгдэж Монголын эдийн засгийн зүрх, дэлхий нийтийн анхааралд хэдийнэ оржээ. Гэхдээ говийн малчид айдастай. Уул уурхайн олон төсөл нутаг орных нь усны нөөцөд сөргөөр нөлөөлөх вий гэх болгоомжлол юм. Оюутолгой мэтийн дэлхийн хэмжээний том орд ашиглалтад орох нь эдийн засгийн хувьд ашигтай хэдий ч /Монголын Засгийн газар төслийн ашгийн 34 хувийг эзэмшиж энэ нь ойролцоогоор Монгол Улсын эдийн засгийн жилийн үзүүлэлтийн 30 хувийг бүрдүүлнэ/ байгаль экологийн хувьд сүйрэл дагуулж ч болзошгүй юм. Говийн бүсэд жилд дунджаар 100 орчим мм тунадас унадаг. Монгол орны гадаргын усны ердөө 20 хүрэхгүй хувь нь ногддог учир энд байгалийн чийгшил нэн дутмаг хуурай уур амьсгалтай. Тиймээс говь нутгийнхан үндсэндээ гүний усаар хэрэглээгээ хангадаг. Арай ядан ухаж гаргасан худгийн ус нь тэдэнд хүрэлцэхтэй үгүйтэй.

Ус уудаг уул уурхай

Монгол цэвэр усны нөөцөөр бага орны тоонд ордог. Дээрээс нь гадаргын усны тархац жигд бус. Хойд болон баруун хэсгээрээ харьцангуй их байдаг бол зүүн болон говийн бүс нутгаар хомс. Тиймээс нутгийн зүүн хэсгээр газрын гүний усыг ашиглахаас өөр аргагүй. Гэтэл манай усны нөөцийн хувьд урвуу хамааралтай байдаг аж. Гадаргын усны нөөц нь их, гүний нөөц нь бага гэсэн үг. Гэтэл усгүй говьд “усны мангаа” уул уурхай ажилахаас өөр аргагүй болчихоод байдаг. Говийн бүс нутгийн 135 хавтгай дөрвөлжин км газарт дунджаар 3.8 сая толгой мал бэлчээрлэхэд өдөрт 31.600 шоо метр ус хэрэглэдэг гэх судалгаа бий. Харин нутгийн оршин суугчдын өдөр тутмын усны хэрэгцээ дунджаар 10.000 шоо метр байдаг. Гэтэл Дэлхийн банкны судалгаагаар Оюутолгойн нэг өдрийн усны хэрэглээг 67.000 шоо метр, харин төрийн өмчийн Тавантолгой нүүрсний уурхайн 76.000 шоо метр гэж тогтоосон байна. Гадаргын усны нөөцгүй говьд Оюутолгой тэргүүтэй томоохон төсөл үйл ажиллагаагаа явуулахын тулд дээрх мэт усны хэрэглээгээ газрын гүнээс ашиглахаас өөр замгүй. Гэхдээ 2019 онд бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэх Оюутолгой усны хэрэглээндээ дэлхийн хэмжээнд сайн жишиг тогтоохоор ажиллах гэнэ. Тухайлбал, тэд нийт усны хэрэглээний 80 гаруй хувийг дахин ашиглана. Харин дэлхийн улс орнууд ашигласан усныхаа 60-70 хувийг дахин ашигладаг бол Оюутолгойн уурхай түүнээс даруй 10-24 хувиар илүү усыг эргүүлж ашиглахаар төлөвлөн ажиллаж байгаа нь усаар цангамал Монголын говьд ээлтэй технологи болох юм. Оюутолгойн усны эх үүсвэрийг Гүний хоолой гэх газрын гүний усаар хангахаар төлөвлөж байгаа. Уг газар нь төслийн талбайгаас хойд зүгт 80 орчим км-ийн зайд байрладаг. Одоогоор ус татах хоолой тавих ажил бараг дуусч байгаа аж. Гүний Хоолой уст давхарга төслийн 696 л/сек –ээр 27 жил орчим ашиглах (ойролцоогоор 878 сая м3) усны хэрэглээг бүрэн хангах нөөцтэй. Түүгээр зогсохгүй мөн Оюу Толгой эсвэл бусад төслүүд цаашид ашиглахад хангалттай их нөөцтэй. Хэдий тийм ч говийн хөрсөн доорхи ус нөхөн сэргээгдэх эсэхийг мэдэхгүй. Энэ талаар Оюутолгойн гүйцэтгэх ерөнхий захирал Камерон МакРей хэвлэлд өгсөн ярилцлагадаа “Нөхөн сэргээгдэх боломжгүй байлаа гэхэд төслийн хэрэгжилтийн эхний 30 жилд бид усны нөөцийн ердөө 20 хүртэлх хувийг ашиглана. Уг нөөцийг манай төслөөс өөр хэн ч ашиглахгүй, өөрөөр хэлбэл энэ нь олж нээхээс



өмнө өөр хэн нэгэн ашиглаж байсан дундын нөөц биш гэсэн үг” гэсэн байна.

Төрийн лүндэн

Монголын төр ногоон хөгжилд “за” гэж хэлдэг болсон. Түүний нэг илрэл нь өнгөрөгч онд Байгаль орчны тухай багц хуульд орсон томоохон өөрчлөлтүүд юм. Тэр дундаа Ус ашиглалтын тухай хуульд орсон өөрчлөлт төдийгүй Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуультай болсон нь үүнийг батлана. Эдгээр хуулийн өөрчлөлт, шинэ дүрэм журмын гол санааг товчхон өгүүлэхэд Монгол орны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаад, дотоодын ямар ч аж ахуйн нэгж, албан байгууллага байгалийн нөөцийг зөв зохистой ашиглах учиртай. Эс бөгөөс өндөр төлбөр төлнө. Аль эсвэл үйл ажиллагаагаа зогсоо гэж хатуухан шаардах хууль, эрх зүйн орчин бүрдсэн гэсэн үг. БОНХЯ-ны Усны мониторинг, зохицуулалтын хэлтсийн дарга Г.Мөнх-Эрдэм “Байгалийн нөөц ашиглалтын төлбөрийн тухай хууль батлагдсан. Энэ бол шинэ механизм. Учир нь уг хуулиар усыг үрэлгэн хэрэглэдэг технологиос татгалзах механизмыг оруулж ирсэн гэж хэлж болох юм. Хуульд хэд хэдэн зүйлийг нарийн тусгаж өгсөн байгаа. Нэгдүгээрт, та усанд үрэлгэн технологи ашиглавал тэр хэмжээгээр өндөр төлбөр төлнө. Хоёрдугаарт, ашигласан усаа стандарт түвшинд хүртэл цэвэршүүлж дахин ашиглахгүй бол нэмэгдэл төлбөр төлнө. Тиймээс хуулийн хүрээнд томоохон аж ахуйн нэгж, уул уурхай гэх мэт ус их ашигладаг албан байгууллагууд усыг хэмнэлттэй ашиглах. Тэр усаа дахин ашиглах учиртай” гэв. Хэрвээ хуулийн хүрээнд ажиллаж чадвал төр төмөр нүүр гаргахгүй. Харин ч төлбөрийн зарим хэсгээс чөлөөлөх юм байна. Мөнх-Эрдэм “Хуулиа сайн унших хэрэгтэй байна л даа. Хэрвээ эдгээр хуулийг анхааралтай уншвал цаад санаа нь үйлдвэрлэлд байгальд ээлтэй технологи ашигла. Тэгвэл төр төлбөр мөнгөнөөс чинь хөнгөлөөд өгье.Байгальд ээлтэй ажиллах нь л чухал. Тэгж чадвал бид урамшуулъя гээд байгаа юм. Хэрвээ чадахгүй бол баяртай” хэмээн учирласан. Монголчуудаас өөр нойлдоо хүртэл ундны усаа литр литрээр нь урсадаг орон ховор. 2011 онд батлагдсан Саарал усны тухай хууль хар ус харамладаггүй гэх ойлголттой монголчуудад дусал усыг ч чандмань эрдэнэ мэт хайрлах цаг нэгэнт болсон гэдгийг сануулсан. Өмнө нь уул уурхайн компаниуд нэг шоо метр усанд 150-хан төгрөг төлдөг байсан. Гэтэл алт олборлохын тулд нэг секундэд 500 литр ус зарцуулдаг гэсэн судалгаа бий. Харин энэ байдал энэ онд өөрчлөгдөж байгаа аж. Засгийн газрын хэлэлцүүлгээр ороод байгаа усны төлбөр тооцооны тухай шинэ журамд энэ талаар маш нарийн тусгагдаж буй юм. Тухайлбал, Орхон голын сав газар гадаргын ус хамгийн үнэтэй байх бол Туул голын савд гүнийн ус өндөр үнэтэй байх жишээтэй. Товчхондоо Засгийн газар уул, уурхайн баялагтаа бардамнах биш, чандмань эрдэнэ болсон усныхаа нөөцөд тулгуурлаж хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхээр төлөвлөж байна.

Усны ирээдүй

Цаашдаа төрөөс гадаргын усыг ашиглах тал дээр бодлогын зохицуулалт хийх гэнэ. Учир нь манай усны нөөцийн ихэнх хувийг гадаргын ус эзэлдэг ч 90 гаруй хувь нь хил гараад урсчихдаг. Тиймээс гадагш урсгалтай гол мөрний усыг ашиглах нь зүйн хэрэг гэдэгтэй бүгд дуу нэгтэй байна. Гэхдээ асуудал бий. “Nestle” компанийн ТУЗ-ын дарга Петер Брабек-Летмать манай сэтгүүлд өгсөн ярилцлагадаа “Ус маш эмзэг асуудал. Тиймээс их болгоомжтой хандах хэрэгтэй. Хэдийгээр Монгол орны ус танай өмч мөн боловч байгаль эх хил хязгаар гэж байхгүй. Тэр утгаараа энд ямар нэг зүйл өөрчлөгдвөл тэнд бас өөр нэг зүйл болдог. Тиймээс хоёр тал хамтран зөвшилцөх нь зүйтэй. Энэ асуудлыг шийдэх хууль эрх зүйн зохицуулалт олон улсын түвшинд байхгүй. Тиймээс танай улс усны урсацаа хааж өөрчиллөө гэхэд хөрш зэргэлдээ орны усны асуудалд цочроо үүсгэхгүй байх нь чухал. Ус нь угаас хүний эрхийн асуудал учраас маш ярвигтай” гэсэн юм. Харин манай улсын хувьд юу юугүй усны урсацыг өөрчлөх тухай асуудал биш. Юуны түрүүнд цас, бороoны усыг хуримтлуулж ашиглах нь эдийн засгийн том хөшүүрэг болно гэж мэрэгжилтнүүд үзэж байна. Хөгжлийн хамгийн чухал асуудал бол ус. Түүнчлэн дэлхий дахинаа усыг улс орны тогтвортой хөгжлийг тэтгэгч гэдгийг хэдийнэ хүлээн зөвшөөрөөд байна. Монголын төр ч ялгаагүй тогтвортой хөгжлийг бий болгохын тулд ус гэгч чандмань эрдэнэд анхаарал хандуулах болсон.



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

ЗҮРХ НЬ МОНГОЛ ЗҮС НЬ МОНГОЛ



Б. ЦЭЦЭЭ

Хүн төрөлхтний түүхэнд уртаас урт цусан мөр үлдээсэн их нүүдлийг эхлүүлсэн эр зориг хоёрхон үндэстэнд байсан. Нэг нь эх орныхоо энгүй тал, эрх чөлөөг мөрөөсөж бүхэл бүтэн тивийг цусаараа хэмжиж, алд газар ахих бүртээ амиараа золиос төлөн Оросын их гүрнийг орхин одсон талын зоригт нүүдэлчин Халимаг үндэстэн. Нөгөө нь Эксодус, Египетээс салан тусгаарласан еврейчүүдийн нүүдэл байсан гэдэг.

Халимаг үндэстнүүд өнгөрсөн дөрвөн зуун жилийн хугацаанд Крымийн татарыг цавчих сэлэм, Францын арми руу шидсэн бугуйл, Түрэгийн цэрэг рүү онилсон сум, Кавказуудын эсрэг босгосон бамбай, Октбярийн хувьсгалын шуурган дундах бамбар болж байлаа. Тэглээ гээд сөхөрч бас цөхөрсөн нь үгүй. Их, бага 28 дайны гал дундуур зугтаж бус цавчилдаж ирсэн. Халимаг үндэстэн нь Монголын их талаас тасарсан амь билээ. Оросын гол холбоотноор тулалдаж явсан баатарлаг гавьяаг алдарт зохиолч С.Пушкин “Талын нөхөр Халимаг” хэмээн шүлгэндээ мөнхөлсөн байх юм.

Эх орны дайны үед Сталины эсрэг Германы талд дайтаж буй нэрийдлээр гэмгүй халимаг олон хүн хэлмэгдсэн билээ. Тэдний дунд одоогийн АНУ-ын халимаг монгол иргэн "Номадик Экспедишнс" компанийн ерөнхийлөгч Жалса Урубшуровын эцэг эх байжээ. Азаар 1952 оны үед Толстой сангийн тусламжтайгаар Америкт ирсэн 580 гаруй халимаг иргэдийн дунд түүний эцэг эх байсан агаад тэд халаасандаа тавхан дойч марктай хүний нутагт хөл тавьсан гэдэг. Долоон наснаасаа аавыгаа даган дайны дараах их бүтээн байгуулалтад хөлс хүчээ зориулсан нь хожмоо барилгын салбартай ажил амьдралаа холбох эхлэл болсон байна. Сэтгэлийн дуудлага, зүрхний уяа Монгол нутаг нь 20 жилийн өмнө халх Монголын их хүмүүнтэй түүнийг учруулж, аялал жуулчлалын салбартай хазаарлаж орхижээ.

-Хэдийгээр Америкт төрж өссөн ч таны судсаар Халимаг үндэстний цус гүйж байгаа. Тэр ч утгаараа анх удаа Монголд ирсэн сэтгэгдэл тань харийнхны сониучирхлаас арай ондоо байсан болов уу. Тэр үед төрсөн сэтгэгдлээсээ хуваалцахгүй юу?

-Анх Монголд ирээд харсан бүхэн сэтгэлийг минь татсан. Хаашаа л харна монгол төрх. Тиймээс байсхийгээд л “Зогс” гээд машинаа урагш явуулдаггүй байлаа. Америкт байдаг манай халимаг иргэдийн дүүрэгт халимаг хүмүүс байдаг ч тун цөөхөн. Би анх Монголд ирээд хар зах орж үзсэнээ мартдаггүй. Хүмүүс “юу авах вэ” гэж монголоор асуугаад л, гайхаж харах нь байтугай тоох ч үгүй байсан нь ер бусын мэдрэмж байв. Монголчуудаар хүрээлүүлэх ямар байсныг үгээр илэрхийлэх ч аргагүй. Монгол гэж бидний хятад японучуудаас ялгардаг хаана ч олж харсан таних тэр л царай. Тив алгасч төрсөн ч гэлээ өвөг дээдсийн минь



нутаг учир Монголоо би эх нутгаа гэж боддог. Ийм л учраас би Нью Йоркийн алдарт Таймс талбайгаас илүүтэй хар захад очих дуртай. Өнгөрсөн хугацаанд олон удаа Монголд ирсэн ч ирэх бүрийд анхны удаа мэт санагдаж, буцах тоолонд дахин ирмээр санагддаг.

-Та Монголоор их сайн ярьж байна. Америкийн иргэн биз дээ?

-Аав минь монгол хэлээрээ ярихын чухлыг бидэнд ойлгуулж, үе хойчдоо хэл соёлоо хадгалж үлдэхийг сургадаг байсан. Тиймдээ ч манай гэр бүл Америкт удаан амьдарсан ч, гэртээ үргэлж монголоор ярьдаг байв. Халимаг монголчууд Оросын нутагт 400 жил үүний дараагаар Америкт 50-60 жил болсон. Мөн би Америкт төрж өссөн мөртлөө аавынхаа ачаар аялгуу сайхан эх хэлээрээ өөртэй чинь ярьж сууна. Халх монголчууд нэг дор амьдарч байгаа учир хэл нь харьцангуй шинэчлэгдэхийн зэрэгцээ хялбарчлагджээ. Харин халимаг нь баруун монголчуудын нэг аялга тул арай ондоо, түүнчлэн хэдэн зуун жил хүний нутагт амьдарсан тул хэл соёлоо хадгалж үлдэх хэцүү шүү дээ. Увс аймгийн Дөрвөд үндэсний айлд зочилж, бидэнтэй адил аялгаар ярьдаг хөгшинтэй хуучилж билээ. Баруун Монголоос гаралтай хүний хувьд уугуул хэл тэр дундаа нутгийн аялгаараа хөөрөлдөнө гэдэг онцгой завшаан. Манай гэр бүл мөнгө төгрөгийн хувьд баян байгаагүй ч үндэсний бахархал, өв соёлоороо баян байлаа.

-Өвөг дээдсийнхээ өлгий нутаг тэр дундаа Монголын аялал жуулчлалын салбартай ямар учралаар хэдийд холбогдов оо?

-Ардчилал тогтсоны дараахан буюу 1990-ээд онд Ардчилсан Монголын анхны Ерөнхий сайд Д.Бямбасүрэн тэргүүтэй улс төрийн төлөөлөгчид Америкт айлчлахдаа намайг урьсаны дагуу намар нь Монголд ирж үзсэн. Тэрбээр надаас Монголын аялал жуулчлалыг өрнөдөд тэр дундаа Америк улсад сурталчлан таниулахыг хүсч, Жуулчин компанийнхантай танилцуулж байлаа. Өвөг дээдсийнхээ нутагт буцаж ирмээр байсан учир өрнөдөд таниулах санаачилгыг уухайн тас зөвшөөрсөн юм.

-Хэдийгээр Монгол элэг зүрхнээс уяатай эх орон тань ч гэлээ ардаа амьдралтай бизнесмэн хүний хувьд энэ улсыг бараг хэн ч мэддэггүй байсан 1990-иэд оны үед чухам юунд найдаж энэ ажлыг эхлүүлсэн юм бэ?

-Анхны аяллаа бид 1992 онд төрийн өмчийн “Жуулчин” компанитай хамтран зохион байгуулж байлаа. Монгол гэдэг үг “алс хол” бас “үл таних” гэдэг утгыг гаднынханд төрүүлэх нь элбэг байсан тул аялал жуулчлалын шинэ гарц болгоно гэдэг амар байгаагүй. Тэр үед Монголд жилдээ 100 хүрэхгүй Америк хүн ирдэг байв. Монголд хоёр дахь удаагаа ирэхдээ одоогийн "Номадик Экспедишнс" компанийн дэд захирал Ё. Бадралтай танилцсан бөгөөд улмаар 1996 онд “Номадик Экспедишнс” компанийг байгуулсан юм. Аяллаа сурталчилж эхлүүлсэн цахим хуудас маань Монгол орны тухай хамгийн анхны вэб хуудас болж байлаа. АНУ-д суугаа Монголын Элчин сайдын яам мөнгө санхүү, хүн хүчний хувьд дутмаг байсан үе тул мэдээлэл лавлах гэж бидэн рүү утас цохидог эсвэл дэлгэрэнгүй мэдээлэл ав гэж манайхыг зааж өгдөг байв. Монголд ирсэн бас нэгэн зорилго нь эко-бааз байгуулах байв.

Бадрал тэр үедээ шинээр гарч ирж буй залгамж үе байлаа. Өөрөөр хэлбэл, хоёр өөр цаг үед хөл дүрж үзсэн нэгэн байв. Тэр миний юу хийх гэж оролдоод байгааг маш сайн ойлгож байсан. Монгол бол жуулчдын хөлд даруулах газар биш. Дэд бүтэц муудаа бус харин нүүдэлчин уугуул амьдрал иймл байх ёстой юм. Монгол өндөр өртөгтэй аялал жуулчлал хөгжсөн орон байж чадна.

-Монголын аялал жуулчлалын салбарын хөгжил хаашаа чиглэж байна вэ?

-Огцом урагшилж байна. Барууны жуулчид олноороо Монголд аялдаг болж. Үүнийг дагаад үйлчилгээний салбар ч гэсэн хүчтэй хөгжиж байна. Улаанбаатар хотод ериэд оны үед “Star” зочид буудалд анх пицца идэж байснаа санадаг. Намайг тухайн үед ирж байхад ердөө 450 шахам хувийн авто машин байлаа. "Нарантуул" зах эзэнгүй шахуу. Их дэлгүүрийн ойр орчимд хүүхдүүд хөлбөмбөг тоглодог тийм л байлаа. Гэтэл өнөөдөр зам дээр 490 мянга гаруй машин холхиж байна. Өнгөрсөн 22 жилийн хугацаанд энэ бол үсрэнгүй өсөлт. Мэдээж сайн муу хоёр талтай.

Эко аялал жуулчлалыг хөгжүүлэх тал дээр идэвх үнэхээр сул байна. Монгол бол Дисней Лэнд, Мексикийн далайн эрэг, Францын өмнөд хэсэг эсвэл Африкийн Сафари биш шүү дээ. Өөрийн гэсэн онцлог, гоо үзэмж гэж бий. Монголын аялал жуулчлал үзэсгэлэнт байгаль, үндэсний түүх, нүүдэлчин соёл дээр суурилдаг. Хүмүүс Африк, Сэрэнгэтигийн тал газрыг мэдэх ч Монголын зүүн хэсэгт орших өвс халиурсан талыг дуулаа ч үгүй. Энэ бол дэлхийн хамгийн уудам хүний хөл хүрээгүй, хашаа хороо үгүй тал газар юм. Африкийн арслан, заан, хирс зэрэг таван том амьтны талаар ярьцгаадаг. Тэгвэл Монголын Мэнэнгийн талд 1.5-2 сая цагаан зээр бэлчээрлэдэг. Энэ нь Африкаас гадуурх туурайтан амьтны хамгийн том сүрэг Азид байна гэсэн үг. Мөн Монголын говьд дэлхийд ховордсон зэрлэг хавтгай, мазаалай зэрэг амьтад байна.

Хэдийгээр нүүдэлчин соёл иргэншил өөрчлөгдөж буй ч оршин тогтносоор байна. Би Монголын нүүдлийн соёл устана гэж боддоггүй. Тэдний хувьд амьдралын хамгийн ногоон буюу байгальд ээлтэй хэлбэрээр амьдардаг. Нүүдэлчид амьдралын дэвшилтэт хэв маягийг хүсэмжилж буй ч орчин цагийн хэлбэртэй зохицон амьдарч чадаж байна. Хөдөө бүгд л мотоцикл унан давхилдах ч шатахууны үнэ өсмөгц морио унаад эхэлдэг. Монголын хүн амын 40 хувь нь таван хошуу малынхаа ашиг шимээр амьдралаа залгуулж байна. Олон зуун жил оршин тогтносон нүүдэлчин амьдрал устах нөхцөл байхгүй.

-Ирэх жилүүдэд аялал жуулчлалын салбарт тулгарах томоохон сорилтууд юу байх бол?

-Байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх, улмаар байгаль орчноо хамгаалах мөн энэ салбарын үндсэн оролцогчдын хүсэл зориг юм. Аяллын операторууд ганц удаагийн аялал хийх гээгүй л бол байгаль орчноо хамгаалах асуудлаар өөрсдийн оролцоог бий болгох ёстой. Учир нь энэ бол нэг талаар тэдний л бизнесийн нөөц хөрөнгө шүү дээ. Эвдэж сүйтгэхийг зөвшөөрөөд сууна гэдэг ирээдүйгээ үгүй хийж байгаа л хэрэг. Энэ зөвхөн Монголын бус дэлхий нийтийн асуудал. Дэлхийн аялал жуулчлалын консул энэ талаар судалгаа хийж байна. Тогтвортой байдлыг эрхэм зорилгоо болгон ажилладаг компаниуд үргэлж нөгөөдүүлээсээ илүү ажлын бүтээмж, орлоготой байдаг.

Манай “Гурван тэмээт” бааз дусал усыг ч нарны эрчим хүчээр халаадаг. Эхний ээлжинд жижиг гэр баазуудын хувьд дээрх шийдэл нь хөрөнгө оруулалтын хувьд хүндрэлтэй байж болно. Гэвч үүн дээр Засгийн газар л дэмжээд өгөх хэрэгтэй юм.

-Дэд бүтцийн сул хөгжил аялал жуулчлалын салбарын гацаа гэдэгтэй санал нийлдэг үү? Эсвэл эсрэгээрээ хэт өндөр хөгжчихвөл олны хөлийн газар болж Монгол сэтгэл татам чанаруудаа алдахад хүрнэ гэдгийг дэмждэг үү?

-Тэнцвэрийг барих хэрэгтэй. Байгальд мэдрэмтгий онцгой бүсүүд бий. Малын хөлөөс хол байхын зэрэгцээ зам барихыг хориглох шаардлагатай газрууд байгаа. Засгийн газрын хувьд энэ бас нэгэн чухал асуудал болоод байна. Гол замуудыг дайруулалгүй тойруулж, хэсэгчлэх, шаардлагатай хэсгүүдэд зам тавихыг би эсэргүүцдэг хүн. Өртөг өндөртэй аялал жуулчлалын талд зогсдог учир хэт тооны араас хөөцөлдсөн аялал зохимжгүй гэж үздэг.

Хөвсгөлийг хар л даа. Нуурын баруун эрэг бол том алдаа. Стандартын шаардлага хангаагүй 34 гэр жуулчны бааз нэг дор байна. Бусдад үзүүлдэг үзэсгэлэнт нуур руугаа бохир усаа хөрсөндөө шингээх замаар цутгачихдаг. Хөвсгөл бол шууд ууж болдог цэнгэг устай нуур. Дэлхий дээр ийм нуур олон байхгүй. Орчин үеийн байгальд ээлтэй технологи бүхий бохир усны суваг, зохицуулалттай баазыг л хүлээн зөвшөөрөх ёстой юм. Энэ бол сонголт биш үүрэх ёстой хариуцлага.

-Шинэ Засгийн газрын шийдвэрийн дагуу аялал жуулчлалын салбарын бодлогыг спорт, соёлын салбартай нэгтгэсэн. Та энэ талаар юу хэлэх вэ?

Аялал жуулчлал дэд бүтцийн яаманд харьяалагддаг байсан. Миний бодоход аялал жуулчлалын яам тийм ч үр дүнтэй хэрэгжүүлэгч газар биш байсаар ирлээ. Аялал жуулчлалын

салбарын компани, бааз, зочид буудлуудад тулгардаг асуудлуудын аль нэгийг шийдчихсэн тохиолдол, мэдэгдэхүйц үр дүн өдийг хүртэл байхгүй.

Мөн Байгаль орчны яамны нэг хэсэг байлаа. Миний бодлоор байгаль орчны асуудалтай хамт байхад харьцангуй хоорондоо авцалдаж байсан. Гэсэн ч байгаль орчин эмзэг асуудал болчихсон өнөө үед тустай яамтай байх нь зөв. Соёл, спорт нь яалт ч үгүй аялал жуулчлалын нэг хэсэг байж чадна. Учир нь эко аялал жуулчлал өөртөө соёлыг агуулдаг бол спорт нь соёлын салшгүй нэг хэсэг юм.

-Өнгөрсөн жилийн аялал жуулчлалын өнгө төрх 2011 онтой харьцуулахад танай компанийн хувьд ямар байсан бол?

-Өнгөрсөн санхүүгийн хямралаас хойш бид томоохон бууралтыг амслаа. Хямралын дараах үеэс бид гарах гэж хичээж байна. 2009 оны хямрал аялал жуулчлалын салбарт хүнд цохилт болсон. Тиймээс ч 2009, 2010 он бидний хувьд ихээхэн хүнд жил байлаа. 2010 онд ялимгүй сэргэлт гарч, өнгөрсөн хоёр жилд бид хямралаас сэргэлт рүү зүглэж байна. Тодорхой өсөлт ажиглагдсан жилүүд байлаа гэж өнгөрсөн хоёр жилийг дүгнэе.

-Аялал жуулчлалын бус салбарт өрсөлдөж үзэх санаа оноо Танд байна уу?

-Монголын аялал жуулчлал, гар урлал, урлагтай холбоотой санаа оноо бий. Олон тооны жуулчин хүлээж авдаг манай компанийн хувьд зочид буудлын бизнест хүч сорих хүсэл бий. Хөвсгөлд “Гурван тэмээт” шиг эко бааз барих асуудал газрын маргаанаас үүдэн гацчихсан байгаа шиг зочид буудал барих асуудал ч гэсэн зогсчихсон байна. Хотод ч гэсэн байгаль орчинд ээлтэй зочид буудал барьж болно шүү дээ. Даац, тогтвор сайтай аварга цогцолбор бүхий платиниум зөвшөөрөлтэй мөрийтэй тоглоомын газрууд байдаг. Үүнийг Монголд ч гэсэн бий болгож болно. Томоохон барилга, амины байшин, орон сууц зэрэг сонирхсон талбар бий.

-Аялал жуулчлалын бизнест ирэх жилүүдэд томоохон ямар ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна?

-Бидний дараагийн алхам бол одоогийнхоо улам сайжруулах. Тухайлбал, бид “Гурван тэмээт” баазынхаа цахилгаан хэрэглээг ирэх жилүүдэд нарны эрчим хүчээр бүрэн хангахаар ажиллаж байна.

Дээш өгсөх жижиг шат олон байгаа ч том шат ч мөн цөөнгүй бий. Бидний ирэх жилүүдэд хийх хамгийн том бүтээн байгуулалт бол дэлхий дээрх хамгийн шилдэг байгальд ээлтэй гэр баазыг бүтээн байгуулах ажил юм. Энэ нь өндөр түвшинд гарсан “Гурван тэмээт” бааз байж болох ч өөр нэгэн шинэ бүтээн байгуулалт ч байж болно. Хурдан баяжих төлөвлөгөө эс бөгөөс доллар шууд олборлоод эхлэх уурхай байдаггүйтэй адил, ганц том алхана гэж байдаггүй.

Цөвүүн цагийн эрхэнд Монголоо орхин одож хүний нутгийн усыг ууж, уулыг дэрлэх бэрх хувь заяаг эдэлсэн ч хэл, соёлоо умарталгүй өдийг хүрсэн Халимаг түмний үргэлжлэл энэ эрхэм өөрийн үйл хэрэгтээ ч үндэсний үзлээ тусгаж яваа нь энэ. Хамтын хүч, хариуцлагыг эрхэмлэдэг тэрбээр байгалиа хайрлах, хамгаалах, хадгалах уриалыг үгээрээ бус үйлдлээрээ үзүүлж яваа нэгэн. Тэнэгэр говийн алс хязгаарт сүндэрлүүлсэн тансаг түүний харшийн амин сүнс нь нар ба салхи. “Хэрэв зочид буудал, баазууд хэдэн одтойгоороо өрсөлддөг бол манай баазын дээр 5000 од бий” хэмээн Жалса гуай хошигнох дуртай. ■



Зохион байгуулагч:

WORLD TRADE CENTER®
ULAANBAATAR

ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ ТӨВ УЛААНБААТАР ТББ

САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Хамтран зохион байгуулагч:

МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН БИРЖ

MISHEEL GROUP
EXPO - FURNITURE - BUSINESS PARK

МИШЭЭЛ ГРУПП ХХК

САНХҮҮГИЙН АНХДУГААР ҮЗЭСГЭЛЭН, СУРГАЛТ СЕМИНАР

2013

МОНГОЛИА

ФИНАНС

МОНГОЛЫН САНХҮҮГИЙН АНХДУГААР ҮЗЭСГЭЛЭН, СУРГАЛТ СЕМИНАР



МИШЭЭЛ ЭКСПО 2013.2.22-24



ҮЗЭСГЭЛЭНД

- АРИЛЖААНЫ БАНКУУД
- ББСБ-УУД
- ДААТГАЛЫН КОМПАНИУД
- АУДИТЫН КОМПАНИУД
- БРОКЕР, ДИЛЕРИЙН КОМПАНИУД
- ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООД

ОРОЛЦОНО

БҮРТГЭЛ ЭХЭЛЛЭЭ



70111533, 95950811, 99071751, 88077063

www.financemongolia.com

MONGOLIA MINING 2013

ОЛОН УЛСЫН УУЛ УУРХАЙН ҮЗЭСГЭЛЭН

мишээл экспо төв

2013.04.19-20

www.mongolia-mining.org



БҮРТГЭЛ ЯВАГДАЖ БАЙНА

ОЛОН УЛСЫН УУЛ УУРХАЙН ҮЗЭСГЭЛЭН 3 ДАХЬ УДААГАА

- Mongolia Mining экспо нь Монголын уул уурхайн салбарын хамгийн чухал үзэсгэлэн
- Цаг хугацааны хувьд хамгийн тохиромжтой: Уул уурхайн улирал эхлэн, худалдан авалт хамгийн идэвхитэй байх үед болдог
- Дэлхий дахины техник технологитой мөр зэрэгцэн өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчилах боломж
- Боломжит худалдан авагч, ханган нийлүүлэгч, бизнесийн шинэ түншүүдтэйгээ уулзах гайхалтай орчин
- Ашигтай хөрөнгө оруулалт олж авах бололцоог олгодог

Зохион байгуулагч:

MINEX MONGOLIA

Дэмжигч:

Government of Mongolia Ministry of Mining

Mongolian National Chamber of Commerce and Industry

nacimo

Mining Leaders

Mongolian Economy

TOP EXPO.MN

Үзэсгэлэнд бүртгүүлэх хаяг:

Улаанбаатар 17032 Чингисийн өргөн чөлөө 98 Хан-Уул дүүрэг, Лүүк Монголиа байшин 3-р давхар,

Утас: 344488 Факс: 343757; www.mongolia-mining.org

info@mongolia-mining.org